

04 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Цар тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын зэргийг сунгахтай холбоотой гарсан аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд хяналт шинжилгээ хийх заалтыг сум болон холбогдох агентлаг, төсөвт байгууллагуудад хүргүүллээ.

2021 онд шинээр гарсан ЗГ-ийн 9 тогтоолын 11 заалт, ЗГ-ын хуралдааны 4 тэмдэглэлийн 4 заалт, нийт 13 шийдвэрийн 15 заалтын биелэлтийг гаргаж Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахимаар хүргүүллээ.

13 сум, 27 агентлагийн 2020 оны тайланг архивын нэгж үүсгэн архивлахаас одоогийн байдлаар 13 агентлаг, 12 сумын баримтыг цэгцлэн бэлэн болгоод байна.

Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад **4302** өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний **4064** өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт **94.4** хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй **238** өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.

2021 оны 1-р улирлын байдлаар Аймгийн Засаг даргад хандаж гаргасан 14 өргөдөл бичгээр болон Засаг даргын тамгын газрын нээлттэй утсаар ирсэн байна. Эдгээрээс нэг иргэнд гэр, эмчилгээний зардал хүссэн нэг иргэнд 500,000 төгрөгийн мөнгөн тусламж олгосон байна.

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал

/2021 оны 1-р улирлын байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлтийн хувь
1	Аймгийн ЗДТГ	14	14	-	-	-	100
2	Агентлаг	2213	2175	-	-	38	98.2
3	Сумд	2075	1875	-	-	200	90.3
	ДҮН	4302	4064	-	-	238	94.4

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

Улсын төсөвт- **950,831,5** мянган төгрөг төвлөрүүлэхээс **1206241,3** мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 126.9 хувиар, орон нутгийн төсөвт **2,989,793,0** мянган төгрөг төвлөрүүлэхээс **3,463,819,2** мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 118.5 хувиар тус тус биелүүлсэн байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 14,640.8 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 3,090.4 сая төгрөгийн орлого орж нийт 17,731.2 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Байгууллага бүрээр батлагдсан төсвийн хүрээнд зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын 4-р сарын зарцуулах эрхийг хянаж, нийт өссөн дүнгээр ТЗШилжүүлгийн байгууллагуудад 11,3 тэрбум, орон нутгийн байгууллагад 3,8 тэрбум, санхүүгийн дэмжлэгт 2,1 тэрбум төгрөгний санхүүжилтийн эрхийг олгож ажилласан.

Аймгийн төсвөөс сумдад 2,110.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 17,372.0 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/247 дугаар захирамжийн дагуу ХХОАТатварын 2020 оны татварын тайлангаар баталгаажсан татвараас орлого чөлөөлүүлэх, албан татварын хөнгөлөлт эдлэх 738 иргэдийн хөнгөлөлт чөлөөлөлтийн 357,396,847.33 төгрөгний дүнг хянан баталгаажуулж, буцаан олголтыг олгах ажил хийгдэж байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэж Зөрчилгүй санал дүгнэлт авлаа.

Статистикийн хүрээнд: Аймгийн нийгэм эдийн засгийн 1-р улирлын танилцуулгыг салбар бүрийн гол гол үзүүлэлтүүдээр нэгтгэн гаргаж тархаасан.

ААНБ-ын үйл ажиллагаанд Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн 3 дугаар сарын судалгаанд 76 ААНБ-аас 76 ААНБ-ыг бүрэн хамруулсан.

Бизнес регистрийн санд шинээр байгуулагдсан 23 ААНБ-ийн мэдээллийг оруулан баталгаажуулсан.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй 'Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох' судалгаа нь 2021 оны 04 дүгээр сарын 6-аас 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулагдсан бөгөөд уг судалгаанд аймгийн хэмжээнд 31 агентлаг, албад болон төсөвт байгууллага болон 13 сумын 92 байгууллагын нийт 3769 төрийн албан хаагчид хамрагдсан байна.

Худалдан авах ажиллагааны хүрээнд: Аймгийн Засаг даргын 2020 оны А/684 дүгээр захирамжаар батлагдсан "2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу 2021 оны 04 дүгээр сард tender.gov.mn сайтаар дамжуулан нийт 16 бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарлаад байна. Үүнээс дахин зарласан 1, үнэлгээг хийгдээгүй байгаа 3, хугацаа нь болоогүй байгаа 6 тендерүүд байна.

04 сард нийт **4,05,200,000** төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендерийг зарлаж, үнэлгээний хорооны гишүүдийн олонхийн саналаар тендерт оролцогчийг сонгон шалгаруулсан бөгөөд нийт 3,976,126,170 төгрөгийн үнэтэй 10 бараа, ажил, үйлчилгээний тендерийн үнэлгээг хийж, захиалагч байгууллагад зөвлөмж хүргүүлсэн байна. Хэмнэлт 99,073,830 төгрөг байна.

Өмчийн бүртгэл, хяналтын хүрээнд: 2020 оны сүүлийн хагас жилд хөрөнгийн мэдээллийн системд гэмтэл гарсан учир ашиглах боломжгүй байгаа тул Орон нутгийн өмчит 140 хуулийн этгээдийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээг захиргааны статистикийн маягтуудаар 2020 оны жилийн эцсийн байдлаар урьдчилан гаргуулан авч, нэгтгэж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

2021 оны 04 дүгээр сард байгууллагуудаас ирсэн саналыг судлан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 2 тогтоолын төсөл бэлтгэн оруулж, 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 29, 30 дугаар тогтоолоор тус тус “ Үндсэн хөрөнгө бүртгэх, эзэмшүүлэх тухай шийдвэрүүдийг гаргуулан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө бүртгэж эзэмшүүлэх шийдвэрт хяналт тавин ажилласан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дугаар тогтоолоор “ Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу 2 байгууллагаас ирсэн саналын дагуу хөрөнгийг нүд үзэж тоолон, эд хөрөнгийг актлах болон шилжүүлэн данснаас хассан.

Хяналт шалгалтын мэдээлэл: Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газарт санхүүгийн хяналт шалгалт, Баруун-Урт сумын Тэмүүлэл, Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дотоод аудитын шалгалтууд тус тус хийж байна.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2021 оны 04-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 627 иргэнээс эмэгтэй 278, бүртгэлтэй ажилгүй иргэн 478 иргэнээс, эмэгтэй 214 иргэн байна. 78 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 57 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 37 нь байнгын ажлын байртай болсон байна.

Ковид-19 цар тархалтын улмаас Аймгийн Засаг даргын А/201 захирамжаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 4 дүгээр сарын 12-ны 06:00 цаг хүртэл тэг зогсолт хийж мөн үргэжлүүлэн 04 сарын 10-ны өдрөөс 25-ныг хүртэл улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор борлуулалтын цэгийн үйл ажиллагаа түр зогсонги байна. Цахимаар дэмжлэгт хамрагдаж үйл ажиллагаа явуулж байгаа иргэнийг иргэдтэй зуучилж холбогдох утсаар холбуулан хэрэгтэй бараа бүтээгдэхүүний захиалга авч гэрээрээ үйлдвэрлэлээ эрхлэн ажиллаж байна.

Төсөл хөтөлбөртэй холбоотой мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэх постерийг бэлтгэж газрын цахим хуудсанд болон аймгийн зарын группүүдээр байршууллаа.

Төрийн худалдан авалт “Үндэсний үйлдвэрлэл-2021” цахим үзэсгэлэнд худалдаанд оролцох 2017-2020 онд Төсөл хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаа явуулж байгаа 11 иргэдтэй холбогдож үзэсгэлэнд оролцох бүтээгдэхүүний судалгаа гаргаж материалыг хүргүүлэв.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111-н хэрэгжилтийг хангах ажлаар Сумын ХЭХАХ мэргэжилтэн нарт Засгийн газрын тогтоол, судалгааны маягтыг албан тоотоор хүргүүлж, аргазүйн зөвлөгөө өгч аймгийн хэмжээнд 25 ба түүнээс дээш ажилтантай 44 байгууллагаас судалгааг авч нэгтгээд байна.

Нийгмийн халамжийн талаар: 2021 оны 04-р сард 6 сумын 24 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 6 иргэний ахмадын хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн 6 хувийн хэргийг хүлээн авч нийгмийн халамжийн Wais программд баталгаажуулсан. E halamj прорграммд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрийн 20, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн 84, жирэмсэн эхийн 75, насны хишгийн 8 үйлчилгээг хүлээн авч хянан баталгаажуулсан. Тус сард олгох:

- 309 иргэний 92,377,200 мянган төгрөгийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр ,
- 1346 иргэний 159,472,800 мянган төгрөгийн тэтгэмж ,
- 19 иргэний 2,195,000 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт,

- 151 иргэний 4,421,710 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн жагсаалтыг тулган хаан банк, төрийн банкруу илгээсэн.

"E-halamj" цахим системээр олгогдох:

- 940 иргэний 262,524,545 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон ахмад настны тэтгэвэрийн,
- 555 иргэний 21,037,334 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж,
- 3131 иргэний 153,305,910 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн жагсаалтыг тулган баталгаажуулж төрийн сан илгээсэн.

Сумдын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, гэрээт хүнсний дэлгүүрүүдэд 5 дугаар сараас НӨАТ төлөгч дурын хүнсний дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүнээ авдаг болохтой холбогдуулан өрхийн цахим картыг пин коджуулах, коронавируст халдварын үед халдвар хамгаалаллын дэглэмийг мөрдөх, өрхөд хүргэлтийн үйлчилгээг үзүүлэх ХХҮГ-ын даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/110 тоот албан чиглэлийг хүргүүлсэн.

04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 7 бүлгийн 7 төсөл бусад материалын хамт хүлээн аваад байна. Ковид-19 халдвар дотоодод тархсантай холбогдуулан Олон нийтийн оролцооны бүлгийн төслийг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсан.

Аймгийн улаан загалмайн хорооноос албан бичиг ирсэний үндсэн дээр шаардлагынхан дагуу хүнсний талон авдаггүй, өрх толгойлсон эх/эцэг/, хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьжиргааны түвшин доогуур 236 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн түвшинг шалган 120 зорилтот бүлгийн өрхүүдийн жагсаалт гарган Улаанзагалмайд хүргүүлээд байна

Эрүүл мэндийн чиглэлээр: Коронавируст халдварын Эрсдэлийн үнэлгээг 3 удаа хийж авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, 3 сарын 28-с эхлэн хорио цээрийн дэглэм тогтоож, халдвараас сэргийлэх, бууруулах зогсоох үйл ажиллагааг Шуурхай штабын 9 баг 14 бүлэг 140 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдож салбар хоорондын уялдааг холбоог хангаж, хариу арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллалаа.

Батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх халдвартын 20 ор, уламжлалтын -50 нийт-70 ор ажиллаж байгаагийн зэрэгцээ нэмэлтээр Нэгдсэн дотуур байранд хөнгөн өвчтөнийг эмчлэх-100 ор дэлгэн бэлэн байдлыг хангасан.

Тусгаарлан ажиглах байр 13 сумын 21 байранд 151 иргэнийг хүлээж авахаар бэлтгэсэн.

Коронавируст халдварын нөхцөл байдлын талаарх болон НЭМ-ийн сургалт, сурталчилгаа, мэдээллийг иргэдэд өдөр бүр хүргэж байна.

Халдвар голомтлон бүртгэгдсэн сумдын 596 айл өрхөд ӨРХИЙН БАГЦ олгосон

Халдвар бүртгэгдсэнээс хойш гадна талбайд 542485, дотор талбайд 547043 нийт 1089528МК талбайд халдваргүйжүүлэлт хийсэн байна.

Ковид-19-ын эсрэг вакцин татан авч дархлаажуулалтын үйл ажиллагаа нийт 18 байнгын цэг, 4 түр цэгээр зохион байгуулж 98,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад арга зүйн зөвлөмж өгөх 6 удаагийн цахим сургалтыг давхардсан тоогоор 385 эмч эмнэлгийн ажилчдад зохион байгуулсан.

Тохиолдол бүртгэгдсэнээс хойш буюу 03 дугаар сарын 29ний өдрөөс 04 дүгээр сарын 27ны өдрүүдэд PCR-ын шинжилгээг – 4309, түргэвчилсэн шинжилгээг -6678 хүнд хийсэн байна.

Боловсролын чиглэлээр: БШУЯ-наас "Чадварлаг багш" хөтөлбөрийн хүрээнд **"Дэлхийн түвшний менежер бэлтгэх 1000 багш"** сургалтад ерөнхий боловсролын сургуулийн захирал 16, сургалтын менежер 10, мэргэжилтэн 1, нийт 27 хүн хамрагдаж сертификат авсан.

"Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тохиолдуулан "Титэм-Арт" академийн санаачилгаар Үндэсний бичгээ сэргээн хэрэглэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар

аймгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын нийт албан хаагчид, ЕБС-ийн багш, сурагчдын дунд “Жаахан шаргын нутаг” монгол бичгийн уралдааныг зохион байгуулж байна.

“Их нүүдэл” системтэй хамтран аймгийн даалгаврын санг бий болгох сургалтад БСУГ мэргэжилтэн, ЕБС-ийн сургалтын менежер, мэргэжлийн багш нар 8 ээлжээр сургалтад хамрагдсан.

Дэлхийн том хичээл- Тогтвортой хөгжлийн боловсрол" - үндэсний хэлэлцүүлгийн хүрээнд зарлагдсан хичээл төлөвлөлтийн уралдаанд Сүхбаатар аймгаас 15 хичээл илгээж 7 хичээл "ШИЛДЭГ" -ээр шалгарч Тогтвортой хөгжлийн боловсролын хичээлийн үндэсний санд бүртгүүлж улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэхээр боллоо.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ЕБС-д лаборатори байгуулж, сургалтын орчинг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ЕБС-ийн 16 сургуулиас судалгаа авч худалдан авах төндэрийн тодорхойлолтыг боловсруулав.

Хүүхэд хамгааллын чиглэлээр анги удирдсан багш нарт зориулсан цахим сургалтыг аймгийн ХГБЗХГ, үндэсний сургагч багш Ундраа нартай хамтран зохион байгуулж ЕБ-ын 16 сургуулийн анги удирдсан багш нарыг хамруулсан.

Мерит төслөөс Канадын төрийн албаны шилдэг туршлагад үндэслэн Монгол Улсын онцлогт тохируулан боловсруулсан Сургалт 1 - "Жендэр, жендэрийн эрх тэгш байдлын үндсэн ойлголт", Сургалт 2- "Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ" нэртэй 2 шатлалт цахим сургалтад 16 удирдах ажилтан хамрагдаад байна.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй MERIT төслөөс дэмжлэг үзүүлэн боловсруулсан төрийн албан хаагчдад зориулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт – шинжилгээ, үнэлгээ” цахим сургалтад БСУГ-ын 6 мэргэжилтэн, ЕБС-ийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар хамрагдсан.

БШУЯ-наас 2020-2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын талаар цахим хурал хийж аймгийн ЗДТГ, БСУГ, ГХБХБГ-ийн холбогдох дарга, мэргэжилтнүүд, гүйцэтгэгч компаний удирдлагууд оролцож санал хүсэлтээ солилцлоо.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдэх боловсролын салбарын 13 ажлын саналыг цахим программд шивэх ажил хийгдлээ.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах Баруун Урт сумын ерөнхий боловсролын 2-р сургуулийн урлаг заал, Дарьганга сумын 150 хүүхдийн цэцэрлэг, Баяндэлгэр сумын 300 суудалтай соёлын төвийн барилгуудын төндөр зарлагдлаа.

Нийтийн номын сан: Эх хэл-Соёлын дархлаа цахим булангаар дамжуулан бичвэр болон зурган хэлбэрээр файл оруулан үндэсний бичгээ суртачлан түгээх, унших, монгол бичгээр хэрхэн бичих дадалд хэвшүүлэхээр ажиллаж байна. Энэ хугацаанд уг буланд нийт 3502 хүний хандалт авсан байна.

Дэлхийн номын өдөрт зориулан Сүхбаатар нутгийн уран бүтээлчдийн 30 гаруй яруу найрагч, чөлөөт уран бүтээлийг видео болон файл хэлбэрээр хүлээн авч сар гаруй хугацаанд нийтэд түгээхэд уншигчид талархан хүлээн авлаа. 659890 гаруй хандалт авсан байна.

Угсаатны зүйн музей: Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музейгээс Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран 04-р сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Соёлын өвийг хамгаалах тухай ерөнхий ойлголт" , "Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт анхаарах асуудал" сэдэвт цахим сургалтад музейн мэргэжилтэнүүд, сумдын бүртгэл мэдээллийн санч нар, Орон нутаг хариуцсан албан хаагчид хамрагдлаа.

2020 онд шинээр бүртгэгдсэн түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг RCH программд оруулсанаар Сүхбаатар аймгийн хэмжээн дэх дурсгалын тоо 100 орчмоор нэмэгдэж 1500 гаруй боллоо.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хууль, эрх зүй: Аймгийн Засаг даргын тамгын газар, ХЭЗХ –ийн даргаар ахлуулсан

ажлын хэсэг Эм эмнэлгийн хэрэгсэл өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнд үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол гарч буй эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 7 бөөний худалдааны төв, захын 35 дэлгүүрээр 2 удаа явж үнийн хөөрөгдлийн судалгаа авч, Аймгийн шуурхай штабт танилцуулж мөн аймгийн BBS телвизээр мэдээлэл хийсэн.

Архивын чиглэлээр: 11 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн холбогдолтой 21 тушаалын хуулбар, малын А дансны лавлагааг 1 иргэнд шийдвэрлэж өгөөд байна.

Улсын бүртгэлийн чиглэлээр: Тус хэлтэс 2021 оны 04 дүгээр сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-33, анхны бүртгэл-25, өмчлөх эрх шилжих гэрээ-23, барьцааны гэрээ-248, бүртгэлд өөрчлөлт оруулах -9, лавлагаа хуулбар-8, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-97

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-142, анхны бүртгэл-6, өмчлөх эрх шилжих гэрээ-20, барьцааны гэрээ-100, бүртгэлд өөрчлөлт оруулах -7, лавлагаа хуулбар-3 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-32

Хуулийн этгээдийн улсын бүртгэл

2021 оны 04 дугаар сарын 30-ны байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо 4 Үүнээс ХК-0, ХХК-4, төрийн бус байгууллага-0, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -0, Төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар-1, нөхөрлөл-1, хоршоо-0, хадгаламж зээлийн хоршоо-0, сан-0, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-1, шашны байгууллага-0, хэвлэл мэдээллийн байгууллага-0 бүртгэгдээд байна. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-3, татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-0, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-4, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт - 4, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналт лавлагаа олгосон -0, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг 4 –г тус тус бүртгэн хурааж авсан байна.

Иргэний бүртгэл: 2021 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 88 төрөлт, гэрлэлт 4, үрчлэлт 1, эцэг тогтоолт 4, овог нэр өөрчлөлт 3, нас баралт 19, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 9, үндэсний энгийн гадаад паспорт 3, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 17, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 276 тус тус олгосон байна.

Шүүхийн шинжилгээний алба: Албаны бие бүрэлдэхүүн цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнтэй хамтран хэргийн газрын үзлэгт 7 удаа оролцсоноос, хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 1 удаа, хулгайн хэргийн дуудлаганд 4 удаа, бусад дуудлаганд 2 удаа явж, хэргийн газрын үзлэгээр гарын мөр 2 ширхэг, гутлын мөр 8 ширхэг, бусад ул мөр, эд мөрийн баримт 7 ширхэг, нийт 17 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авсан байна.

Криминалистикийн шинжээч нар нь тайлангийн хугацаанд мөр судлалын 2 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Тус албаны шинжээч эмч нар нь хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 38 удаа хийснээс хүнд 3, хүндэвтэр 3, хөнгөн 16, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 9, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй 7 дүгнэлт гаргасан байна. Мөн бэлгийн маргаантай хэрэгт 2 дүгнэлт гарган ажилласан.

Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 1 хүнд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Шинжээч эмч нар нь химийн 5 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Аймгийн Цагдаагийн газар баривчлагдсан 8 хүний гарын дардасыг авч, лавлагаа авах хүсэлтийн дагуу 15 хүний гарын хээний лавлагаа мэдээллийг албаны даргын зөвшөөрлөөр олгосон.

Цагдаагийн газар: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 91, 104 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 10, 25-ны өдрийн хурлын шийдвэрээр “Улаан” түвшин”-нд шилжүүлсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2021 оны 05 сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл тус тус сунгасан байна.

Дээрх шийдвэрийн дагуу бүх сумдаас гарах, орох хөдөлгөөнийг хязгаарлаж, хорио цээрийн дэглэм сахиулах баталгаат 46, баталгаат бус 24, нийт 70 хяналтын постод цагдаагийн 22, бусад байгууллагын 123, нийт 145 ажилтан, алба хаагч, 69 автомашинтай үүрэг гүйцэтгэж байна.

Аймаг, сумдын төвийн доторх хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор 120 цэгт, цагдаагийн 51, бусад байгууллагын 385, нийт 436 ажилтан, алба хаагчид эргүүл, хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажиллаж байна.

Аймгийн онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Баруун-Урт сумын хэмжээнд хүргэлт, түгээлтийн үйлчилгээ үзүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн мөрдөж байгаа байдалд аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын энэ оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/200 дугаар захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосонтой холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран Баруун-Урт сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй 61 аж ахуй нэгжийн 173367 ширхэг согтууруулах ундааг тоолж, лацдав.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Хүүхдийн эрх ба аюулгүй байдал” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Уг арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын 4 сургуулийн 105 сурагчдыг унаач хүүхдийн судалгаанд бүртгэн, 36 уяачдад мэдэгдэл зөвлөмж өгч, эргүүл хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний хүрээнд хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх чиглэлээр 3 удаагийн санамж, сэрэмжлүүлэг, мэдээллийг цахим орчинд түгээсэн.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Хүүхэд хамгаалал” ерөнхий арга хэмжээний хүрээнд бэлтгэгдсэн цахим орчин, ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх 2 төрлийн постерийг цагдаагийн газрын пэйж хуудас болон аймгийн олон дагагчтай 40 фейсбүүк группт түгээж, иргэдэд сурталчилсан. Мөн хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдтэй өдөр бүр уулзаж, үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрийн худалдагч, худгийн ус түгээгч зэрэг 25 иргэнд зөвлөгөө өгч, гарын авлага тараасан.

Аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн 14 хоногийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудлын талаар цахим танилцуулга бэлтгэн, байгууллагын пэйж хуудсанд байршуулж, иргэд олон нийтэд сурталчлав.

Баруун-Урт сумын замын хяналтын постод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 3 ширхэг хяналтын телекамер /дотор талд 1, гадна талд 2 ширхэг/ суурилуулж, цагдаагийн газрын Шуурхай удирдлагын өрөөнөөс шууд хянах боломжтой боллоо.

Улсын Онцгой комиссоос тус аймагт хуваарилсан БНХАУ-ын "СИНОФАРМ" үйлдвэрийн 4500 хүн тун вакцины эхний тунг 2021 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр татан авч, аймгийн иргэдийг вакцинжуулах ажлыг эхлүүлсэн. Энэхүү вакцинжуулалтын эхний ээлжид тус цагдаагийн газрын алба хаагчдын 99.0 хувь нь хамрагдсан.

Хүн хүчний дутагдалтай байгаа энэ үед цагдаагийн газрын "Ахмадын зөвлөл"-тэй хамтран цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 30 ахмад ажилтныг 2021 оны 04 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд хорио цээрийн дэглэм сахиулах 5 цэгт үүрэг гүйцэтгүүлж, ахмад ажилтнуудынхаа дархлааг дэмжиж ажиллалаа.

Сумдад эргүүл, постод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг халдвараар сэргийлэх, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор цагдаагийн 125 алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн 12 сонсогчид нийт 6588 ширхэг маск, 138 ширхэг гар ариутгагч олголоо.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2021 оны сургалтын хөтөлбөрийн хүрээнд НХЖХОНАБХА-аас 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан "Хэсгийн байцаагчийг чадавхжуулах нь" сэдэвт цахим сургалтад тус газрын хэсгийн байцаагч нар хамрагдаж байна.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:

Уул уурхайн салбарт: Аймгийн Засаг даргын 2021 оны А/249 дугаар захирамжаар Сүхбаатар сумын 3-р багт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Каскейд майнинг" ХХК-ийн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн чиглэлийн маршрутыг түр баталсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/248 дугаар захирамжаар Сүхбаатар сумын 5-р баг "Дөрвөлжин худаг" нэртэй талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг "Бөөндий" ХХК-д 3 жилийн хугацаатай олгосон.

ОУИТБС-ын үндэсний зөвлөлийн ажлын албанаас 4-р сарын 6-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалт, хэлэлцүүлэгт холбогдох албан тушаалтнууд оролцож, аймгийн хэмжээнд хийж хэрэгжүүлсэн ажил, 2021 оны дэд зөвлөлийн төлөвлөгөөг танилцуулж санал солилцсон. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамнаас энэ онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих орон нутагт эрх шилжүүлсэн авто зам, замын байгууламжийн ажлуудын худалдан авах ажиллагаа, ажлын явцыг эрчимжүүлэх зөвлөмж чиглэл өгөх, санал солилцох цахим уулзалтад орон нутгийн төлөөлөл оролцов.

Зам тээврийн салбарт: 2021-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдах Баруун-Урт сумын 1-р багт баригдах 3,03км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Монгол зам групп" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, гэрээ байгуулах бэлтгэл ханган ажиллаж байна.

2021 онд хэрэгжүүлэх Түмэнцогт, Асгат сумдын чиглэлд гарах авто зам, замын байгууламжийн зургийн даалгавар, 3-р багийн 1.1 км хатуу хучилттай авто зам дагуух явган зам, гэрэлтүүлгийн ажлын техникийн тодорхойлолт, улсын төсвийн хөрөнгөөр аймгийн төвд баригдах 8.68 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник технологийн хяналтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулан батлуулж өмчийн газарт хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа аймгийн төвийн 4 дүгээр тойргийн 9.1 км, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1.1 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлыг энэ онд үргэлжлүүлэх зөвшөөрлийг гүйцэтгэгч компаниудад олгож ажлыг эхлүүлээд байна.

Иргэний нисэхийг ерөнхий газраас ирүүлсэн аймгийн алслагдсан сумдад агаарын хөлөг хөөрч буух зурвас байгуулах, хамгаалалтын бүс тогтоох тухай судалгаа, мэдээлэлтэй танилцаж аймаг, орон нутгийн саналыг судалгаа, төлөвлөлтөд тусгуулахаар хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх авто зам, замын

байгууламжийн төсөл хөтөлбөрийн жагсаалтын саналд орон нутгаас оруулах 3 ажил, арга хэмжээний дэлгэрэнгүй судалгаа, мэдээллийг Сангийн яамны цахим бүртгэлд оруулан ажиллаж байна.

2021 оны 4-р сард аймгийн Бичигтийн боомтоор “Петрожайна Дачин Тамсаг” ХХК-ийн 149,4 мян.баррел газрын тос, 3 аж ахуй нэгжийн 62,4 мян.тн хүрэн нүүрс, 316 тн төмрийн хүдэр, 377 тн жонш экспортлогдсон байна.

Эрчим хүч, шуудан харилцаа холбооны чиглэлээр: 35кВ-ын Халзан, Онгон, Уулбаян, Асгат, Эрдэнэцагаан сумын ЦДАШ-ын трассын дагуух үзлэгийг хийж, Баруун-Урт сумын 10/04кВ-ын ТП№07,13,14,109,110,124, дэд станцуудын тоноглолд цэвэрлэгээ хийх, тр тос нэмэх, тоноглолын чангалгаа хийсэн АТП№18,19,23,22 дэд станцын тр оруулганы кабель солих, АТП№81,16,93,08,88,05, дэд станцуудад гэрэлтүүлэг хийх, монтаж засварлах ажлыг тус тус хийсэн.

Баруун-Урт сумын зам дагуу байрлалтай, машин мөргөх эрсдэл бүхий 22 тулгуурт овоолго хийж аюулгүй байдлыг хангасан.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт: Аймгийн хэмжээнд төллөвөл зохих 1.7 сая мал байгаагаас 1.15 сая мал төллөлж мал төллөлт 67.7%-тай явагдаж байна. Үүнээс нийт төллөвөл зохих бог малын 72.5% буюу 1.07 сая, бод малын 33% буюу 71 мянган толгой мал төллөөд байна. Гарсан төл 1.15 сая, бойжиж буй төл 1.14 сая буюу төл бойжилт 98.3% байна.

Мал сүргийг бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, баяжуулах, хяналт тавих тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх ажлын хүрээнд улсын хэмжээнд мал сүргийг хувийн дугаартай болгож, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, мал бүртгэлжүүлэх ажлын үр дүн, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор "Мал бүртгэлжүүлэлтийн аян"-ыг сумдын хөдөө аж ахуйн тасаг болон вэб сайтаар сурталчилан таниулж ажиллаж байна.

Үлийн цагаан оготны хаврын тархалтын судалгааг сумдаас авч нэгтгэж байна. Нийт аймгийн хэмжээнд 9 сумын бэлчээрийн талбайд 150 мян/га-д үлийн цагаан оготно тархалттай, 64 мян/га – д голомтлон тархаад байна.

2021 онд 3 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн өнөөдрийг хүртэлх хугацаанд тус аймагт КОВИД-19 цар тахал бүртгэгдэж, хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан аймгийн “Нөөц хангалтын баг”-ийн “Хүнсний хангамж”-ийн бүлэг ажиллаж байна. Тус бүлэг нь аймгийн хэмжээний хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамжийн мэдээллийг /13 сумаас/ өдөр бүр авч нэгтгэх, аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй томоохон хүнсний 7 дэлгүүрийн түгээлтийн ажиллагаанд хяналт тавих, жижиг дэлгүүрүүдийн нөөц, үйлчлүүлсэн иргэдийн тоо зэрэг мэдээллийг Баруун-Урт сумын багийн засаг дарга нараар дамжуулан авч нэгтгэх, бүлгийн гишүүдийн холбогдох мэдээ судалгааг гаргах хуваарь гаргаж, үүрэгжүүлэн ажиллалаа.

Түүнчлэн аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй Хүнсний үйлдвэр, цех, мах бэлтгэл, хүнсний бөөний худалдаа эрхлэгч 150 хүнийг эхний ээлжийн вакцинд 04 сарын 08 ны өдөр хамруулсан ба 05 сарын 02 ны өдөр вакцинд хамрагдах хүнсний худалдаа эрхлэгч 293, мах бэлтгэлийн 64 иргэний нэрсийн жагсаалтыг гарган Эрүүл мэндийн газарт хүргүүллээ. Ингэснээр Баруун-Урт сумын хүнсний үйлдвэр, цех /гурилан бүтээгдэхүүн, мах бэлтгэл, усны үйлдвэр/, хүнсний худалдааны / бөөний болон жижиглэн/ эрхлэгчид 100 хувь 1 дүгээр тун вакцинд хамрагдах боломжтой болоод байна. Цаашид ахуй үйлчилгээ, газар тариалан, барааны худалдаа, нийтийн хоол, зочид буудал, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн судалгааг гаргаж, вакцинд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

4 дүгээр сарын 30 ны байдлаар Хүнсний хангамжийн талаар товч мэдээллийн танилцуулбал:

Аймгийн хэмжээний Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөц: 2021-04-29 ний өдрийн мэдээгээр аймгийн хэмжээнд мах 27,6 тн, гурил 272,9 тн, гурилан бүтээгдэхүүн 24,0 тн, төрөл бүрийн будаа 78,4 тн, хуурай сүү 21,3 тн, ургамлын тос 16,2 тн, төмс 39,9 тн, хүнсний ногоо 23,0 тн, элсэн чихэр 28,0 тн, давс 17,1 тн, цэвэр ус 33,2 тн, өндөг 2.8 тн-ийн нөөцтэй

Хоногоор тооцвол: Мах 4 , гурил 52 , будаа 30, хуурай сүү 23, элсэн чихэр 16 хоног, ургамлын тос 18 хоног, давс 65 хоног, өндөг, төмс, хүнсний ногоо, гурилан бүтээгдэхүүнүүд 2-5 хоногийн нөөцтэй байна.

Сумдын хувьд хүнсний хомсдол үүсээгүй, бараа татан авалт хэвийн, 3 хоногийн давтамжтай хүнсний дэлгүүрүүд Улаанбаатар хотоос татан авалт хийж байна.

Аймгийн төвийн томоохон хүнсний дэлгүүрүүдийн нөөц, түгээлт: Бөөний 7 дэлгүүрт мах 0,4, гурил 118,7 , гурилан бүтээгдэхүүн 9,8 , будаа 40,8, ургамлын тос 8,1 , төмс 22,3 , хүнсний ногоо 10,5 , элсэн чихэр 12,1 , өндөг 1,7 тн тус тус нөөцтэй. Хүнсний татан авалт хэвийн, хомсдол үүсээгүй.

Махны үйлдвэр, цехийн нөөц: “Түмэнцагаан ноос” хоршоо хонины мах кг- ыг нь 9000 төгрөгөөр зарж байна. /гулуузаар/ 18.0 тн хонины махны нөөцтэй, “Дарьт шүтээн” ХХК ний “Баян тал “ махны цех үйл ажиллагаагаа эхлүүлж, иргэдэд хонины махыг 9500, үхрийн махыг 10000 , мөн дайвар бүтээгдэхүүний таташ бэлтгэн 1 кг-ыг нь 3500 төгрөгөөр тус тус захиалгын дагуу түгээлтээр хүргэн үйлчилж байна. Өнөөдрийн байдлаар хонь 4,0 тн, ямаа 1,0 тн, үхэр 1 тн , нийт 4,0 тн махны нөөцтэй.

Махны захын нөөц, хангалт: 4 сарын 29 ны өдрийн байдлаар Зүүн бүс, Жанжин тулга махны захуудад адуу , хонь , ямааны нийт 0.5 тн махны нөөцтэй. Үхэр адууны мах байхгүй, үнэ өндөр байгаа тул/малчдаас/ авах боломжгүй байна. Үнийн хувьд адууны мах 9.5-11.0 мянга , үхрийн мах 12,0 мянга, хонины мах 10,0-11,0 мянга, ямааны мах 9.0-9,5 мянган төгрөгөөр хүргэлтэр худалдан борлуулж байна.

Мал эмнэлгийн газар: Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, аймгийн мал эмнэлгийн газраас 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээг сум орон нутгийн удирдлага малын эмч мэргэжилтнүүдэд танилцуулах, төр хувийн хэвшил хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, сахилга бат хариуцлагыг дээшлүүлэх, ажил байдалтай танилцаж цаашид хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөөр ажлын хэсэг сумдад ажилласан.

Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбогдуулан 2021 оны 04 сарын 12,13,29-ны өдрүүдэд Баруун –Урт суманд хүргэлтээр мах махан бүтээгдэхүүн зарж борлуулж байгаа хоёр худалдааны төвийн үйл ажиллагаанд хяналт тавьж эрүүл ахуй хүнсний аюулгүй байдлыг ажиллагааг хангаж ажиллах талаар зөвлөмж өгч ажиллалаа. Хүргэлтийн махны чанарын шаардлага хангаагүй махыг буцаан татах, хөргөгч лангууны цэвэрлэгээ түгээлтийн машины тээвэрлэлтийн эрүүл ахуйд хяналт тавьж зөрчил дутагдалыг арилгуулсан.

4 сарын 28-ны өдрийн байдлаар: Хорогдсон малын тоо толгой: тэмээ-23, адуу-1237, үхэр-2604, хонь-12390, ямаа-14124, Устгасан сэг зэмийн тоо: тэмээ-11, адуу-377, үхэр-985, хонь-3635, ямаа-3783, амьтан-406 байна.

Халдваргүйтгэсэн талбай: 1691,2 м.квадрат талбай ариутгасан байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарт: Монгол улсын Засгийн газрын захиалгаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сүхбаатар аймагт хэрэгжиж буй “Зүүн бүсийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах” төслийн багтай 2 удаагийн онлайн хурал зохион байгуулж Сүхбаатар аймгийн ТХХЗөвлөлийг 2021он анхны хурлыг зохион байгуулах,цаашид хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох талаар санал солилцож, Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төвлөлгөөний төслийг боловсруулан хүргүүлээ. ТХХЗөвлөлийн 9 ажлын албадын ахлагч, бүрэлдэхүүнийг

шинээр томилж, Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар, Зөвлөлийн даргад уламжилж, ТХХЗөвлөлийн даргатай санал солилцсоноор 2021 оны 05 сарын 12-ны өдөр Зөвлөлийг хуралдуулахаар товлоод байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилан ирэх 4 жилд орон нутагтаа 2-с доошгүй боловсруулах үйлдвэрийг байгуулахаар зорьж байна. Энэ хүрээнд ноос угаах үйлдвэр байгуулах санаачилга гаргасан ТХХЗөвлөлийн гишүүн “Дөрвөн гэгээн эрдэнэ” хоршооны даргын санаачлагыг аймгийн удирдлагууд болон ТХХЗөвлөлөөр хэлэлцэн боловсруулах үйлдвэр байгуулах 4 га газрын асуудлыг шийдвэрлэх талаар санал солилцон байршлыг тогтоохоор Баруун-Урт сумын Засаг дарга болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран үйлдвэрлэлийн бүсийн газартай газар дээр очиж, танилцан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний санал гаргахаар боллоо.

Ажлын байр нэмэгдүүлж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх 3 хувийн хүүтэй зээл, репо санхүүжилтын бизнес төсөл судлах үйл ажиллагааг орон нутгийн арилжааны банкуудад тасралтгүй явуулах талаар аймгийн Засаг дарга, Монголбанк, Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга нартай санал солилцон банкууд ажиллахгүй байгаа хэдий ч бизнес төслийн судалгааны ажлыг тасалдуулахгүй байх шийдэлд хүрсэн.

2021 оны 04 сарын 15-ны өдрийн байдлаар ажлын байр дэмжих 3 хувийн хөнгөлөлттэй зээлд 156 зээлдэгчийн 7.9 тэрбум төгрөг олгогдож, 16 хувийн гүйцэтгэлтэй байна. Цаашид 333 зээлдэгчийн 23.9 тэрбум төгрөгийн зээл судлагдаж байна. Репо санхүүжилтийн хувьд 29 зээлдэгчийн 2.49 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Жижиг дунд үйлдвэрийн газраас зохион байгуулж буй “Цахим худалдан авалт” сайтад орон нутаг дахь 2021 оны худалдан авах ажиллагаан төлөвлөгөөг байршуулан орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн худалдан авалтын мэдээллийг олон нийтэд хүргэлээ.

Хорио цээрийн үед өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдөл үүсч байна гэх ард иргэдийн гомдлын дагуу Стандарт хэмжил зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран бөөний болон жижиглэнгийн хүнсний дэлгүүрүүдийн өргөн хэрэглээний барааны үнийг судлаж, дүгнэлт гаргалаа. Тус дүгнэлтээр өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдөл үүсээгүй байна.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 4 сарын 15-ны байдлаар Ажлын байр дэмжих зээлийн хүрээнд арилжааны банкуудад давхардсан тоогоор 649 иргэн, аж ахуй нэгжээс 49.1 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирүүлсэн байна. Үүнээс 156 иргэн аж ахуйн нэгжид 7.9 тэрбум төгрөгийн зээлийг 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгосон байна. Одоогийн байдлаар банкуудад 333 иргэн, аж ахуй нэгжийн 23.9 тэрбум төгрөгийн зээл судлагдаж байна.

Зээлийн батлан даалтын санд Баруун-Урт сумын “Дөхөм-Өндөр” ХХК, “Мастер сайн” ХХК- нь нийт 108.0 сая төгрөгийн зээлийн батлан даалт хамрагдахаар хүсэлт гаргаж, зээлийн материалыг хүргэж ажилласан.

Сум хөгжүүлэх сангийн мэдээлийн програмаас 10 сумын 207 зээлдэгчийн мэдээллийг /1387912.2 сая төгрөг/ Монгол банкны мэдээлэлд систем руу холбогдсон.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

Бүх нийтээр мод тарих, ногоон байгууламжий нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 5-р сарын 15-ны Бямба гаригт “Өрх бүр хашаандаа мод таръя” уриатайгаар аймгийн хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар “Тарьц суулгац 2021” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж байна. Мод үржүүлэг, ойжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэдэг 3 ААНБ, иргэний мод үржүүлгийн газартаа тарьж ургуулсан 17 зүйлийн мод

суулгацны нөөц, үнийн судалгааг сумдын ЗДТГ-т хүргүүлж сумдаас нэгдсэн захиалгыг авахад одоогийн байдлаар 5 сумаас 4000 модны захиалга ирүүлээд байна.

Аймгийн төвийн ногоон байгууламжинд тарьсан модны усалгаа, арчилгааны ажилд 52.5 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын гүйцэтгэгчээр Сүхбаатар-Ойжуулалт СДОАнги, Ойжуулалт-Хайлааст ХХК, Шаргын модот цэцэрлэг ХХК-ууд шалгарч гэрээ байгуулах шатандаа явагдаж байна. Мөн Усны машины тендер шалгаруулалтын ажил явагдаж байна.

МХГ-тай хамтран 13 сумын төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч нар болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт “Агаарын бохирдолыг бууруулах нь”, “Байгалийн нөөцийг ашиглагч нь хамгаалагч, нөхөн сэргээч байх”, “Мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” сэдвүүдээр салбарын сургалтыг цахимаар зохион байгууллаа.

Баруун-Урт сумын ЗДТГ-тай хамтран аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр 4 байршил бүхий газарт шинээр 1400 ш модны хэмжилт, тэмдэгжүүлэлтийн ажлыг хийж байна.

Хүрээлэн буй орчин болон гамшгийн талаар авч хэрэгжүүлсэн ажил: Аймгийн Засаг даргын 2021 оны 02 тоот албан даалгаврын дагуу сумдуудруу чиглэл өгч ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд: Түмэнцогт сум Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны А/21 тоот захирамжийн дагуу сумын мал эмнэлгийн тасаг, хөдөө аж ахуйн тасаг, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нартай хамтарч албан даалгаврын дагуу хийгдэх ажлын төлөвлөгөө, гарган сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлын хийж эхлээд байна. Мянганы зам дагуу сумын төвийн ойролцоо хаясан малын сэг зэм, хог хаягдлыг цуглуулан хогийн нэгдсэн цэгт төвлөрлүүлэн хаяж халдваргүйтгэлийг хийгээд байна.

Сумын төвийн мал бүхий иргэдэд орчны цэвэрлэгээ ариутгал халдваргүйтгэлийн талаар санамж зөвлөмжийг хүргэж байна. Устгаад байгаа сэг зэм Адуу- 83 Үхэр-278 Хонь-672 Ямаа-791 Нохой-17 Бүгд- 1841 Малын хашаа хороо -6000м², худаг уст цэг-1500м², нийтийн эзэмшлийн талбай-8600м² тээврийн хэрэгсэл-3000м² Өтөг бууц – 4000м² бэлчээрийн талбай – 6000м² байр оффис-7500 м² Нийт-36,600 м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна. Энэ арга хэмжээнд 54кг л халдваргүйтгэлийн бодисыг зарцуулан ажилласан байна.

БОАЖГ-ын даргын Эзэнгүй хог хаягдал, сэг зэмийг устгах ажлын удирдамжийн дагуу, Баруун-урт сумын эргэн тойронд 5км-ийн градустай газрыг цэвэрлэж ариутгал халдваргүйжилт хийлгэлээ. Малын сэг зэм, Бод малын 40 ш, Бог малын 250 ш, 2500 ш хонины нэхий, 120 тонн эзэнгүй хог хаягдал, Таван малтай хороололын хогийн нэгдсэн цэгийн цэвэрлэгээ, Хөшөө дурсгалын газруудын хог, ногоон хашаа тойрсон гялгар уут хогний түүвэр зэргийг хийж гүйцэтгэлээ.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эрсдэл бүхий Түмэнцогт, Мөнххаан, Эрдэнэцагаан, Асгат, Дарьганга, Сүхбаатар сумдын нийт 1800 айл өрхөд гарын авлага тараах, 800 гаруй иргэдээс гарын үсгийн баталгаа авч ажилласан. Мөн тус сумдын 2800 айл өрхүүдэд түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг масс мессэж илгээх ажлыг Скайтел, УЦУОШГ-тай хамтран 4 сараас 6 сар хүртэл сард 4 удаагийн давтамжтай зохион байгуулж байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шторкийг бэлтгэж орон нутгийн ТВ-ээр 3 сарын турш өдрийн 3-5 удаагийн давтамжтай цацаж ажиллаж байна.

Сумдын байгаль хамгаалагч нарт түймрээс урьдчилан ажлын үүрэг чиглэл өгч Түмэнцогт, Мөнххаан, Эрдэнэцагаан, Асгат, Дарьганга, Сүхбаатар сумдад 3 сарын хугацаанд сар бүр 20 л шатахуун олгож холбогдох байгууллагууд, сумын ЗДТГ-тай

хамтран хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн цахимаар Сүхбаатар аймгийн мэдээ мэдээллийн бүх сайтаар өдөр бүр тогтмол урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Асгат сумын 2-р багийн нутаг Яргайт гэдэг газарт гарсан хээрийн түймэрт 1 бүлэг 6 хүн ажиллаж түймрийг унтраасан. Яргайт гэдэг газарт 7500 га талбай шатаж 41812500 төгрөгийн хохирол учирсан ба шатахуунд 145400 төг, хүн хүч 6, техник 1 дайчлагдан ажилласан.

2021.04.18-ны өдөр 11:50 цагт Дарьганга сумын Бадрах 2-р баг Баянцагаан гэдэг газар /аймгийн төвөөс урд зүгт 140 км-т, сумын төвөөс зүүн зүгт 60км-т Эрдэнэцагаан сумаас баруун зүгт 90км-т/ хээрийн түймэр гарсан. Хээрийн түймрийг унтраахаар ОБГ-с 12 алба хаагч, ГТУА 47 дугаар ангиас 17 алба хаагч, Хилийн цэргийн 0146 дугаар ангиас 18 алба хаагч, Дарьганга сумын ЗДТГ-с 19 албан хаагч, Асгат сумын ЗДТГ-с 6 албан хаагч, Эрдэнэцагаан сумын ЗДТГ-с 23 албан хаагч, малчин 61 иргэн нийт 156 хүн 21 автомашинтай ажиллаж 2021.04.19-ны өглөөний 06 цагт унтраасан. Түймэрт нийт Дарьганга сум 21750 га, Эрдэнэцагаан сум 40000 га нийт 61750 га шатаж 18000 га-ын 90 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Зургаа. Батлан хамгаалах салбарт

Батлах хамгаалахын төв архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Хил хамгаалах ерөнхий газрын хилийн цэргийн төв архивуудад цэргийн алба хаасан тухай архивын лавлагааг хүссэн 8 иргэний хүсэлтийг албан бичгээр гаргуулан олгосон.

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил

Асгат:

Төрийн удирдлагын чиглэлээр: Цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэйгээр тэмцэх,бэтлгэл бэлэн байдлыг хангуулах, тусгаарлах, гэрийн ажиглалтыг сайжруулах сумын Шуурхай штабыг ажиллуулан хөдөлгөөнт болон суурийн постыг 24 цагаар тасралтгүй ажиллуулж байна.Үүнд ТАХ нарыг дайчлан нийт 27 тээврийн хэрэгсэл,55 албан хаагч ажиллаж байна.

Хөл хорио цээрийн дэглэмийг зөрчсөн 3 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 350,0 мянган төгрөгөөр торгох арга хэмжээг авсан 4 иргэнийг хуулийн хугацаанд шалгаж байна.

1-р ээлжийн вакциныг сумын онцгой комиссын гишүүд, болон сургууль,цэцэрлэгийн багш нар,эмнэлэгийн албан хаагчдад 112 тун вакциныг тарьсан.

Төсөв санхүүгийн чиглэлээр: Сумын хэмжээнд COVID-19 вирус гарсантай холбогдуулан хөдөлгөөнт пост болон хариуцлагатай жижүүр ажилласан. Коронавирустай холбоотой 4 сарын гүйцэтгэлээр гүйцэтгэл нь

1. ЗДТГ-ын тээвэр шатахуун зардал 9679,3 / хөдөлгөөнт пост/
2. Сумын хэмжээнд бэлэн байдлын СОК 3300,0 халдвар хамгааллын хувцас ба 3040,0 түргэвчилсэн оношлуур /өөрийн нөөц болон төсвөөс/
3. Шинжилгээ авахад 1065.0
4. Нэг удаа маск , нэг удаа бээлий 340,0

Нийт 18051,9 байснаас төлөгдсөн нь 3420,2 хүлээгдэж буй нь 14631,7 байх ба төлөгдөх зардал ЗДНС 652,4 төлөгдөх эх үүсвэртэй ба үлдсэн 13979,3 төгрөгийн эх үүсвэргүй өр үүссэн байна.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг нийт 154154000 орж ирсэн ба 188669900 төгрөгийн санхүүжилт орон нутгийн газрууддаа олгосон байна. Одоогийн байдлаар 910 татварын дансанд 75175973,94 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль орчин: 2021 оны 04 сарын 23-ны байдлаар Эрдэнэцагаан, Дарьганга сумын нутагт гарсан 2 удаагийн хээрийн түймэрт сумаас 1 бүлэг гарч дээрх 2 сумын нутагт гарсан

түймрийг унтраах ажилд оролцсон. Мөн сумын 2-р багийн нутаг Яргайт гэдэг газарт гарсан хээрийн түймэрт 1 бүлэг 6 хүн ажиллаж түймрийг унтраасан. Нийт 7500 га талбай шатаж 41812500 төгрөгийн хохирол учирсан ба шатахуунд 145400 төгрөг, хүн хүч 6, техник 1 дайчлагдан ажилласан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын хэмжээнд айл өрх, албан газрын орчны цэвэрлэгээг хийлгэж малын хүүр сэг зэм 580, толгой албан газрын ойр орчмын цэвэрлэгээ хийлгэж 10 тн хог айл өрхийн муу усны нүх жорлог ариутгах түүхий эд агуулах 2400м² бэлчээр 80.0м² нийтийн эзэмшлийн талбай 40,0мян м² малын хашаа хороо худаг уст цэг 25800м² гоц халдварт өвчний усгалын цэг 22300м² нийт 284866м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж 1708500 мянган төгрөгний зардал гаргасан байна.

Тус сумын мал төллөлт 56,1 хувьтай үүнд гүү-1568, үнээ-1676, ингэ- 6, эм хонь-26125, эм ямаа-13785 тус тус бойжиж байна

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: 4 сарын хүнсний эрхийн бичгийн олголт 21 өрх 100 хувь хүнсээ авсан байна. Мөн ХЭБ авагч 21 өрхийн банкны картыг коджуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Санхүүжилт орсон тухай мэдээллийг өрх тус бүрт холбогдон мэдэгдэж хөдөөний өрхийн хүнсний олголтыг халдвар хамгаалалтын дэглэмийг баримтлан пост дээр өөрийн биеээр хүргэн өгч ажиллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын онцгой комисс, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын Сумын онцгой комисс, Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн сайдын албан даалгавар, тушаалын хэрэгжилт, тусгаарлан эмчлэх байр, тусгаарлан ажиглах байрны тохижилт, ковидын хамгаалах хувцас хэрэгсэл, эм тариа, ариутгалын бодисын нөөц, хүн хүчний бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

2021.04.24ний байдлаар 216 хүнээс коронавирусын халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийхэд 212 сөрөг, 4 сул эерэг тохиолдол гарсан. Уг тохиолдлыг Дорнод аймгийн БОЭТ-д PCR шинжилгээнд хүргэсэн. Сөрөг гарсан.

Тус сумын хэмжээнд давхардсан тоогоор 103 иргэнийг гэрийн ажиглалтад авсан өнөөдрийн байдлаар 11 иргэнийг гэрийн ажиглалтанд авсан орсон сумын онцгой комиссын гишүүд, ЭМТ-ийн гэрийн ажиглалтыг хариуцсан мэргэжилтэнүүд гэрийнхэнд нь анхааруулга, иргэнд зөвлөмжийг өгүүлж тандалтыг хийлгэж ажилласан. Гэрийн ажиглалтанд 7 хоносны дараа хүн бүрийг түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийн сөрөг гарсан тохиолдолд зөвөлгөө өгч, гэрийн ажиглалтаас гаргаж байна.

ЭМТөв нь эмийн эргэлтийн санд-1.8 сая төгрөгний өр, Тийм пориласт компанид хувцас хэрэгсэл, халуун хэмжигчийн -1.9 сая төгрөгний өр үүссэн.

Боловсрол: Цэцэрлэг: Сургалтын хөтөлбөрийг агууллагын хоцрогдолыг арилгах зорилгоор хүүхдүүдэд насны онцлогт тохирсон гарын авлага бэлтгэн 7 хоног бүр гэрээр тараан ажиллаж байна.

Баруун-урт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Тайлант хугацаанд иргэдэд шаардлагатай багийн Засаг даргын 177 ш тодорхойлолт гаргаж үйлчилсэн. Мөн багийн ажлын алба 85 өрхөөр орж ажилласан.

Төрийн үйлчилгээний оператораас 5-н төрлийн 10 үйлчилгээ лавлагааг гаргаж иргэдэд түргэн шуурхай үйлчилсэн байна.

Иргэдийн Нийтийн Хурлаас сонгогдсон 6 багийн Засаг дарга, Иргэдэд үйлчлэх төвийн дарга, Засаг даргын зөвлөхийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулаад байна.

Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга хүргүүлсэн.

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаа дууссан иргэн, аж ахуйн нэгжид зөвшөөрлийн хугацааг сунган олгосон.

Бөөний дэлгүүрийн үйл ажиллагаа явуулдаг 11 дэлгүүрээс бөөний үнээр татан авсан падаан, өөрсдийн зарж байгаа бөөний болон жижиглэнгийн үнийн судалгааг тус бүрээр нэгтгэж, цахимаар иргэдэд нээлттэй, ил тод үнийг хүргэх үүднээс аж ахуйн нэгжүүдийн цахим хаягаар гол нэрийн барааны үнийг, тухайн бүтээгдэхүүний зурагтай тавиулж иргэдэд үйлчилж байна.

Хүнсний үйлдвэр, түүхий эдийн төв, хүнсний бөөний худалдаа, тусгаарлах байранд хүргэлтийн үйлчилгээ явуулж байгаа Тансаг зоогийн газар, Сод буудал зэрэг 160 аж ахуйн нэгж, иргэд 1-р ээлжийн вакцинд хамрагдлаа. Дараачийн ирэх 1-р ээлжийн вакцинд хүнсний дэлгүүрийн ажилчид хамруулахаар төлөвлөж байна.■

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2021 оны 04-р сарын 15-наас 16-ны өдрүүдэд бөөний төвийн 9 дэлгүүр, захын 14 дэлгүүрээс үнийн судалгааг биечлэн авлаа. Захын дэлгүүрүүд үнэ нэмэгдүүлсэн ямар нэгэн зөрчил илрээгүй.

Улаанбаатар хотоос ирж байгаа барааны үнэ 2 үндсэн шалтгааны улмаас нэмэгдэж байгааг олж тогтоолоо. Үүнд:

- Ачаа тээврийн үнэ нэмэгдсэн. 1 сарын өмнө 1 тн ачаа 80 мянган төгрөг байсан бол яг одоо 1 тн ачаа 100-110 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.
- Улаанбаатар хотод зориудаар барааны хомсдол үүсгэн үнийг тодорхой хувиар хэд дахин нэмж байна. Бөөний төвийн Улаанбаатар хотоос ирсэн падааны үнэ 2021 оны 04-р сард гэхэд 2 удаа өөрчлөгдсөн бөгөөд үнэ өсөж ирж байна. Энэ нь орон нутагт барааны үнэ нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.

Ногоон байгууламж, дэд бүтэц, хог хаягдлын чиглэлээр: Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ОНХС-н хөрөнгөөр 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр 3 багц / мод бут нийлүүлэх, зүлэгжүүлэх, нийтийн эзэмшлийн газарт мод тарих / тендерийг зарлаж шалгаруулалтыг хийж “Шаргын модот цэцэрлэг” ХХК, “Ойжуулалт хайлааст” ХХК – ууд шалгарсан.

Төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, 5-р тойргийн модыг хамгаалах зурвас байгуулах ажилд аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 50,0 сая.төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэн ажиллаж байна.

Дарьганга суманд гарсан хээрийн түймэр унтраах ажилд 2 бүлгийн 21 албан хаагч дайчлан, 2 автомашин, 2 үлээгч аппарат, 21 цохиур, 15 тросон шүүр 620,000 төгрөгийн шатахууныг зарцуулсан.

Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хөл хорионы дэглэмийг 14 хоног үргэлжлүүлэн дотор хөдөлгөөний 50 цэгт хяналтын пост гаргаж төрийн албан хаагчдыг дайчлан ажиллуулсан.

Баруун-Урт сумын хэмжээнд 9 тохиолдол бүртгэгдсэн ба 8 тусгаарлах байрны бэлтгэл бэлэн байдлыг хангах, Баруун-Урт Улаанбаатар постын үйл ажиллагааны бэлтгэлийг тогтмол ханган ажиллаж байна.

Нохой устгалын ажлыг “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ газар гүйцэтгэж байна. Энэ сард нийт 85 нохой устгасан байна.

27 б,в, 36,38-н айлын дээвэр засварын тендерийн зураг төсвийн ажлууд хийгдэж байна.

1,3,4,5,6,7,9-р багуудын тоглоомын талбайн засвар үйлчилгээний ажлын бэлтгэл ажил хийгдэж байна.

Гудамж талбайн нэрэмжит хаягжуулалтын ажлыг сумын ИТХТ-ийн хурлаар хэлэлцэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Хотын төвд 2 жил үйл ажиллагаа явуулаагүй газар эзэмшиж байгаа иргэдийн судалгааг гаргаж мэргэжлийн байгууллагуудтай хамтран тус газрыг эргүүлэн татах ажлыг зохион байгуулж байна.

Иргэдэд үйлчлэх төвийн албан хаагчид корона вирусаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд голомттой бүс нутаг болон Баруун-Урт сумын дам болон ойрын хавьтлын иргэдэд хяналтыг тавин ажиллаж байна. Хяналтыг утсаар болон түүврээр өдөр бүр дам 25 өрх, ойр 10 өрхийг сонгон хөдөлгөөнт хяналтыг хийлээ. Өнөөдрийн байдлаар Баруун-Урт суманд батлагдсан-9, дам хавьтал-120, ойрын хавьтал-48 иргэн, голомтод бүс нутгаас ирсэн-104 иргэн гэрийн ажиглалтад байна.

Багийн нутаг дэвсгэрт 21 хотхоны 116 орц 38, байр нийтийн эзэмшлийн 186110 метр кв-т газарт ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 удаагийн давтамжтай хийсэн.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр: Орох гарах иргэдээс авах асуумжийн хуудас нийт 2500, гэрийн тусгаарлалтын баталгааны хуудас 2500, гэрийн ажиглалтад байгаа иргэдэд өгөх зөвлөмж 2500 ширхэгийг тус тус олшруулсан, харилцаа холбооны хэвийн байдлыг хангаж ажилласан.

Аюултай хог хаягдлыг Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазартай холбогдон тогтмол ачуулах зэрэг ажлыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.

Ковид-19 цар тахал, хөл хорио тогтоосонтой холбогдуулан Христийн сүм, болон Өсөх ундрах дэлгүүрээс нийгмийн хариуцлагын хүрээнд цар тахалтай холбогдуулан амьжиргаа, орлогод хүндээр тусч буй өрхүүдэд хүнсний дэмжлэг өгөх хүсэлтийг ирүүлснийг хүлээн авч 9 багийн нийт 225 өрхийн нэрсийг гарган хүргүүлээд байна.

Боловсрол, соёл, гэр бүл хүүхдийн чиглэлээр: Коронавирус / covid-19 /-ийн эсрэг хамтдаа уралдааны дүн гарлаа. Уралдаанд 9 цэцэрлэг, 3 сургууль, 3 сум, хүүхдийн өөрөө удирдлагын 4 клуб оролцож нийт 28 материал ирүүлсэнийг дүгнэн шалгаруулсан.

Хүүхдийн үдийн цай, хүүхдийн хоолны тендэр шалгаруулах ажлын хэсэг хуралдан харьцуулалтын 8 тендэр, нээлттэй 7 тендэрт үнэлгээ хийж ажилласан.

Баяндэлгэр:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар 2021 онд Алдарт эхийн 2 дугаар зэргийн одон авах 18 эхийн материалыг бүрдүүлэн аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбоотойгоор дараахь шийдвэрүүдийг сумын онцгой комиссоос гаргалаа.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн хугацааг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгаж зохион байгуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэх.

Хөдөлгөөнийг багасгах зорилгоор багуудын иргэдийг тогтоосон хуваарийн дагуу сумын төврүү орж, гарах байдлаар шийдвэрлэлээ. Заагдсан өдрүүдэд зөвхөн тухай багийн иргэд орж гарах ба гачигдал, эрүүл мэндийн шалтгаанаас өөрөөр бусад багийн иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлана.

Дэлгүүр үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг богиносгож 09:00-17:00 цагт байхаар өөрчлөлт оруулсан. Улаанбаатар хот /бусад аймаг, сумд/-руу ачаа тээвэр хийх болон зорчих хүсэлтийг сумын онцгойн саналыг үндэслэн аймгийн онцгой комиссоор шийдвэрлүүлдэг байхаар шийдвэрлэлээ.

Төсөв санхүүгийн чиглэлээр: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан бүх төсөвт байгууллага төрийн аудитын зөрчилгүй санал дүгнэлт гарсан.

Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Суманд халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотойгоор ухуулга сурталчилгааны ажлыг зөвхөн мэдээллийн хэрэгсэл болон цахим хэлбэрээр зохион байгуулах чиглэлийг баримтлан ажиллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д бүртгэлтэй ажил хайгч хөдөлмөрийн насны ажилд орсон 2 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

2014-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрт хамрагдсан 21 иргэний 1396250 төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийлгэхээс 12 иргэн 18,382,0 төгрөгийг төвлөрүүлсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 58 өрхийн цахим картыг пин коджуулах ажил 94,8%-тай явагдаж байна.

Хөгжүүлэхээр сонгосон 30 өрхийн судалгааг гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.

Бүрэн дунд сургууль: Сүхбаатар аймагт Корона вирусын халдвар бүртгэгдсэнтэй холбогдуулан танхимын сургалтын үйл ажиллагааг 03 сарын 29 нөөс 05 сарын 08 хүртэлх хугацаагаар зогссон боловч танхимын бус зайны сургалтын үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байна.

Багш удирдлагууд цахим сургалтад хамрагдан мэргэжил боловсролоо дээшлүүлж байна. Үүнд: Эртэч багш сургалтад 5 багш, Байгалийн ухааны сургалтад 6 багш, Дэлхийн менежмент, их нүүдэл сургуульд суурилсан менежмент, боловсролын чанарын шинэчлэл төслийн сургалтад захирал сургалтын менежерүүд, Цахим хичээл бэлдэх арга зүй сургалтад 15 багш монгол бичиг, дэлхийн том хичээл, интерактив хичээл боловсруулах арга зүй, компьютерийн сургалтуудад хамрагдаж мэргэжил боловсролоо ажлын байрандаа дээшлүүлж байна.

ЕБС-ийн багш ажилчид хуваарийн дагуу 13 ээлжээр давхардсан тоогоор 26 хүн постонд гарч, өдөр бүр 6 хүний бүрэлдэхүүнтэй хариуцлагатай жижүүр ээлжинд гарч ААН албан байгууллага, хувь хүмүүст зөвлөгөө зөвлөмж өгч сумын цагдаагийн тасагтай хамтран ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв: Ковид-19 халдварын түргэвчилсэн шинжилгээг 190 иргэнд хийж 2 эерэг гарсныг аймгийн нэгдсэн мэнэлэг шилжүүлсэн. Голомтын эцсийн ариутгал 150мкв талбайд, голомтын байнгын ариутгалыг 86 мкв талбайд хийсэн. Голомтод бүс нутгаар зорчин ирсэн иргэдийг гэрийн ажиглалтын хугацаа дууссан өдөр ковид-19 халдварын түргэвчилсэн шинжилгээ хийн ажиллаж байна.

Ковид-19 халдварас урьдчилан сэргийлэх Хятад улсын Синофарм үйлдвэрийн Вероцелл вакцины эхний тунг ЭМТ-ийн эмч, ажилчид ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн багш ажилчид, Сумын онцгой комисс, Мал эмнэлэг, Цагдаа, Эрчим хүчний 180 хүнийг бүрэн хамруулсан. Одоо 2 дахь тунг татан авах бэлтгэл ажил явагдаж байна.

Цэцэрлэг: Ажлын байранд өөрийгөө хөгжүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулж арга зүйч, 4 багш 5 удаагийн сургалт зохион байгуулж нийт давхардсан тоогоор 52 багш ажилчид хамрагдсан байна.

“Дэлхийн том хичээл - Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хэлэлцүүлэгийн хүрээнд зарлагдсан хичээл төлөвлөлтийн уралдаанд аймгийн хэмжээнд 4 бүс болон хуваагдаж 1-р шатандаа “Байгальд ээлтэй гутал” сэдэвт хичээлийн төлөвлөлтөөр орж бүсээсээ 1-р байранд шалгарч 2-р шатандаа амжилттай оролцсон.

“Халдвар хамгааллаа чангалцаая” 14 хоногийн аянд нэгдэж ААН-үүдээр 3 удаагийн хяналт хийж 305 гарын авлага тараахын зэрэгцээ байгууллагын цахим хуудас болон бүлгийн дотоод группээр 65 мэдээ мэдээллийг бэлтгэн хүргэсэн байна. Мөн энэ үеэр бүлгийн багш нар хүүхдүүдэд гэрээр ажиллах дасгал даалгаврыг тарааж өгсөн.

Байгууллагын залуучуудаас санаачлан Сумын онцгой комисс, сумын цагдаагийн тасаг, постонд гарч байгаа төрийн албан хаагчиддаа баярлалаа гэж хэлье уриалгыг дэвшүүлэн 5 постонд гарч байгаа төрийн албан хаагчдад халуун хоол, цай, аарц, витаминаар үйлчилж сумын ард иргэдээ уриалга хүргэж ажиллаа.

Соёлын төв: Үндэсний хөгжмийн талаар цуврал танилцуулга бэлтгэн цахимаар хүргэлээ. Мөн гитарын цахим хичээл, Соёлын өвийн тухай, сонгодог урлаг болон урлаг соёл танин мэдэхүйн холбогдолтой мэдээллүүдийг цахим хаягт оруулан ажиллалаа.

Хорио цээрийн дэглэмийн үед номын сангийн үйлчилгээг ард иргэдэд цахимаар хүргэхэд анхаарч 3 тууж 11 өгүүллэгийг цувралаар оруулж уншигчиддаа хүргэлээ. Элсэлтийн шалгалтад бэлтгэж буй багш сурагчид, оюутнууд гэх мэт зайлшгүй шаардлагатай уншигчдад гэрээр ном олгож үйлчилж байна

Мөн аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулж буй Нутгийн зохиолчдын бүтээлийг сурталчилах чөлленжид нутгийн уран бүтээлч Г.Баатарнум, У.Буд, Ж.Адъяасүрэн нарыг оролцууллаа.

Талын найраг уран бүтээлийн цахим уралдаанд А.Буянхүү, В. Санжаадорж нар оролцож байна. Аймгийн тэргүүний уншигч шалгаруулах “Судар эгшиглэн” төслийн 2-р шатанд 1 сурагч 5 багш оролцож байна.

Байгаль орчин: Бүх нийтийн мод тарих өдрийг угтан БОАЖГазарт 670 ширхэг, нийт 5 730 000 төгрөгийн модны захиалгыг хүргүүлээд байгаа бөгөөд энэхүү өдөрт зориулсан “1 өрх 5 мод” уриалгыг гарган шторк, танилцуулгыг бэлтгэн сумын группүүдэд тавьж ард иргэдийг уриаллаа.

Аймгийн засаг даргын хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх албан даалгаврын биелэлтийн хүрээнд ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гаргаж, хаврын хуурайшилтын үед гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга зөвлөмж, мэдээ мэдээллийн 5 шторкыг сошиал группүүдэд түгээн ажиллалаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 29 ны өдрийн А/200 тоот “ Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай ” захирамжийн дагуу 2021 оны 04 дүгээр сарын 02- ны өдөр Цагдаагийн тасаг, мал эмнэлэгтэй хамтран кароаке хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч нарт захирамжийг танилцуулж архи согтууруулах ундааг худалдан борлуулахыг хориглож 3 караоке, 9 дэлгүүрийн 4606 ширхэг согтууруулах ундааг тоолж битүүмжилсэн.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээлэл төв банкинд бүртгэгдэж байгаатай холбогдуулан 53 зээлдэгчийн мэдээллийг нэг бүрчлэн зээлийн гэрээ, дансны хуулагтай тулгаж зөрчлийг арилгасан.

04 дүгээр сард сум хөгжүүлэх сангаас 5 иргэнд 18,0 сая /арван найман сая / төгрөгийн төслийн зээл олгохоор зээлийн гэрээ хийсэн.

Малын хорогдол бүгд 8290, адуу- 87, үхэр- 447, хонь- 3779, ямаа- 3977. Мал төллөлт бүгд 127929, ингэ- 60, гүү- 1840, үнээ- 3267, эм хонь- 74705, эм ямаа- 48057 төллөсөн байна.

Мал эмнэлгийн чиглэлээр : Өнөөдрийн байдлаар сумын хэмжээнд адуу-87, үхэр-447, хонь-3779, ямаа-3977 бүгд -8290 мал хорогдсон мэдээтэй байна. Үүнээс сумын төвийн ойролцоох болон төв зам дагуу, мөн бэлчээрт ил задгай хаясан хорогдсон адуу-25, үхэр -63, хонь-565, ямаа-885 амьтан-6 бүгд 1544 малын сэг зэмийг ачин хогийн цэгт булж устган суперкилл бодисоор халдваргүйтгэл хийсэн.

Мөн нийтийн эзэмшлийн талбай-11800 мкв, хашаа хороо- 10100 мкв , өтөг бууц- 8250 мкв, худаг ус-1400 мкв, бэлчээр-6050 мкв, устгалын нэг цэгийг тус тус ариутгаж халдваргүйжүүлсэн.

Ковид-19 гарсантай холбоотойгоор сумын төвийн 43 албан байгууллага, аж ахуй нэгж, үйлчилгээний газрын 56.6 мянган м/кв талбайд ЗДТГ, МЭҮН- н 5 аж ахуй нэгж хамтран ариутгал халдваргүйтгэлийг хийж ажиллаа.

Дарьганга:

Сумын ИТХТ-ээс хэлэлцэн шийдвэрлэж төрийн одон медалиар 3 иргэнийг шагнуулах, алдарт эхийн одонгоор 12 эхийг шагнуулахаар шийдвэрлэж материалыг хүргүүлээ.

“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн” нөхцөл байдлын үед /4-р сард/ сумын Онцгой комисс 10-аас дээшгүй бүрэлдэхүүнтэйгээр танхимаар 2 удаа, 1 удаа цахимаар хуралдаж цаг үеийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Үүнд: оношлуур авах, төрийн албан хаагчдыг дархлаажуулах, ариутгал халдваргүйүүлэлт, эргүүл постын шатах тослох материал зэрэгт нийтдээ 6,772,500 төгрөгийн зардал гарсан. 2021 оны эхний 1-4 сарын байдлаар 22 сая төгрөгийн зардал тооцоо судалгааг хийж, аймгийн Онцгой комисс, Төсөв, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

Сумын Засаг даргын захирамжаар “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа”-г 2021.05.10 ны өдрийн 09.00 цагт зохион байгуулахаар шийдвэрлэв.

Сумын Засаг даргын захирамжаар “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон “Архинд донтох өвчтнийг эдгэрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагыг дэмжих тухай” засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/166 дугаар захирамж зэргийг хэрэгжүүлэх зорилгоор “АРХИНЫ ХЭРЭГЛЭЭГҮЙ ЗАЛУУСЫН НЭГДЭЛ”, “АЗ ЖАРГАЛЫН ЭРЭЛЧИД-ТАЛ НУТГИЙН ЗОРИГТ ШОНХОРУУД” бүлгүүдийг дэмжиж хамтран ажиллах “МЭРГЭЖИЛТНИЙ БАГ”-ийг Засаг даргын орлогч даргаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй томиллоо.

Сум хөгжүүлэх сангийн зөвлөл хуралдаж нийт 41 сая төгрөгийг зээлийг 7 төсөл хөтөлбөрт олгохоор шийдвэрлэв.

Ковид-19 ын цар тахлын нөхцөл байдалдтай уялдуулан нөхцөл байдал хүндэрсэн үед ажиллах нөөцийн судалгааг гаргаж одоогоор Анагаах ухааны сургуульд сурч буй оюутан 15, тэтгэвэрт болон ажилгүй байгаа 10, нийт 25 хүнийг бүртгээд байна.

Сургалт сурталчилгааны чиглэлээр: “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, Хяналт шинжилгээ-үнэлгээ” сэдэвт сургалтад өнөөдрийн байдлаар 20 албан хаагч хамрагдаад байна.

Сумын ИТХ-ын 10 төлөөлөгч “Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан авлигын эсрэг сургалт”-д цахимаар оролцсон.

Hural.mn сайтын админуудын цахим сургалтад сумын ИТХ-ын ажлын албанаас оролцсон.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажилтай холбогдуулан Hural.mn сайтын сургалтад 16 албан хаагч оролцсон.

Сургууль, цэцэрлэгийн талаар: Дэлхийн номын өдөртэй холбогдуулан Ардын боловсролын тэргүүний ажилтан, ахмад багш Н.Цэвэлмаа агсаны нэрэмжит “Унаган багын ухаарлын адис”, “Уянгын тойрог” тэмцээнийг Ахмад багш Д.Дугарсүрэн 1,5 сая төгрөгийн санхүүжилтээр ивээн тэтгэж зохион байгууллаа. Үүнд бага ангиас 50, дунд анги-15 сурагчид хамрагдсан.

Хөдөөгийн малчин өрхийн хүүхдүүдэд нэмэлт дасгал даалгавар хүргэх зорилгоор “Оюуны илгээмж” үйл ажиллагааг зохион байгуулсан. Уг үйл ажиллагааг хичээл хийх 14 хоногийн хугцаанд хийх даалгаврыг хичээл тус бүрээр бэлтгэн багц болгон дархлаа дэмжих витаминь хамт хүргүүлсэн. Нийт 248 сурагч буюу 46.1% нь хамрагдсан. Мөн багш нар дасгал даалгаврыг бэлтгэн хашааныхаа гадна уутанд хийн эцэг эхэд нь хүргэн ажиллаж байна.

“Дэлхийн том хичээл -Тогтвортой хөгжлийн боловсрол” уралдаанд сургуулийн хэмжээнд бага-2, дунд-2 судлагдахуун хамтран 4 хичээлийг бэлтгэн БСГ-т явуулсан

Дунд ангийн 18 багш цахимд 6-11-р ангийн сурагчдадаа нийт 28 хичээлийг бэлтгэн цахимд байршуулсан. Үүнээс 8 багш 11 цахим хичээлийг бэлтгэн байршуулсан бол 10 багш Google meet болон Zoom ашиглан 17 төрлийн хичээлийг бэлтгэн амьд харилцаа үүсгэн хичээлээ заасан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Том малын зүй бус хорогдол өнөөдийн байдлаар Бүгд 2091 үүнээс адуу 100, үхэр 143, хонь 905, ямаа 943 хорогдолтой байна. Төл бойжилт 63 хувьтай, бойжилт 99 хувьтай байна.

Оготно тархалтын судалгааг багийн Засаг дарга нараас авч нэгтгэн аймгийн ХХААГ-т мэдээлэлсэн. Оготно тархсан 15500 га газар байна. Үүнээс голомтлосон 5000 га болно.

Мал эмнэлгийн тасгаас 4 хүний бүрэлдэхүүнтэй ариутгал халдваргүйтгэлийн баг ажиллаж 4 дүгээр сард 2 удаа ариутгалыг нийтийн эзэмшлийн зам талбай-14000 м/кв, аж ахуйн нэгжийн 31 байгууллагад 23140 м/кв, айл өрх- 28 буюу 19600 м/кв, жорлон -53 буюу 848 м/кв талбай, нийтдээ 43,588 м/кв талбайд хийлээ.

Хөдөлмөр халамжийн чиглэлээр: "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2021" сарын аяны хүрээнд төлөвлөгөө гарган, үйл ажиллагааг цахим орчинд зохион байгуулж байна.

"Дарьгангад үйлдвэрлэв" борлуулалтын цэгт 4-р сард 1200,0 төгрөгийн борлуулалт хийгдсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 34 өрхийн цахим картыг пин коджуулах ажил 94%-тай явагдаж байна.

Хөгжүүлэхээр сонгосон 27 өрхийн судалгааг гаргасан.

Байгаль орчны чиглэлээр: Асгат сумын Их-Уул багийн "Зүүн яргайт" гэдэг газар / аймгийн төвөөс зүүн урд зүгт 150 км, сумын төвөөс урд зүгт 100 км-т/ хээрийн түймэр гарсан тухай дуудлагыг 2021.04.11-ний өдрийн 13:30 цагт хүлээн авч Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нар ажиллаж түймрийг бүрэн унтраасан ба нийт 12500 га талбайг түймэрт өртсөн мэдээ гаргасан.

Мөн энэ сарын 19-нд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Бадрах 2-р баг Баянцагаан гэдэг газар /аймгийн төвөөс урд зүгт 140 км-т, сумын төвөөс зүүн зүгт 60км-т Эрдэнэцагаан сумаас баруун зүгт 90км-т/ 4 сарын 18-ны 11:50 минутад хээрийн түймэр гарсан ба түймрийг 4 сарын 19-ний өглөөний 09 цагт нутгийн иргэд болон сумын Засаг даргын тамгын газрын албан хаагчид, Эрдэнэцагаан сумын Гал унтраах 046 дугаар ангитай хамран унтраасан. Одоогоор шатсан талбайн га болон хохирол тогтоох ажлыг Хамгаалалтын захиргааны хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч ажлын хэсгийн хамт ажиллаж байна.

Нийтийн их цэвэрлэгээг 2021.04.23 ны өдөр зохион байгуулж 130 төрийн албан хаагч, 20 гаруй иргэд ажилласан. Сумын төвд нийт 3 тн хогийг түүж нэгдсэн цэгт хаяв.

Эрүүл мэндийн чиглэлээр:Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтын 1-р тунг эрүүл мэндийн төвийн эмч ажилчид, сумын онцгой комиссын гишүүд, ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн багш ажилчид, ачаа тээврийн жолооч, аж ахуйн нэгжийн ажилчид гэх зэрэг нийт 126 иргэнийг вакцинжуулаад байна.

Соёлын чиглэлээр : "Дэлхийн номын өдөр"-ийг тохиолдуулан сумын Соёлын төвөөс "Манай гэрийн номын сан" сэдэвт уралдааныг 2021.04.14 нөөс 2021.04.22 ны өдрүүдэд цахимаар зарлаж, бичлэгийг хүлээн авахаар ажиллаж байна.

Мөнххаан:

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний чиглэлээр: Мөнххаан суманд Ковид-19-ын 91 тохиолдол бүртгэгдээд байна. Хэвтэн эмчлүүлээд гарсан 70, сумын хэмжээнд. Сумын хэмжээнд PSR –шинжилгээнд давхардсан тоогоор 1889 иргэн хамрагдаад байна. Гэрийн тусгаарлалт, гэрийн ажиглалтад нийт 280 иргэн байгаагаас гэрийн тусгаарлалтад 247, гэрийн ажиглалтад 33 иргэн байна.

Дархлаажуулах вакцинд 546 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан. Сумын хэмжээнд 12 хөдөлгөөнт пост 1 суурин пост сумаас орох, гарах хөдөлгөөнд хяналт хийж ажиллаж байна. Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажилд нийт сургууль , цэцэрлэг,соёл, цагдаа ,эрүүл мэндийн төв, ЗДТГ-ын 60 гаруй төрийн албан хаагчид дайчлагдан ажиллаж байна.

2021 оны 03 сарын 29 ноос 04 сарын 22 ны байдлаар: Халдвар хамгаалалтын хувцас 12690,0 ,бензин шатахуун 15400,0, түргэвчилсэн оношлуур 350 ш 7875,0, PSR-ын оношлуур

1000ш 1650,0, хоол хүнс 1663,6, утас нэгж 550,0, бичиг хэрэг 237,5 төгрөгийн зардлын тооцоо гарч нийт 40066100 төгрөгийн зардал гарсан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: 04 сарын 12-ны өдрөөс эхлэн ЭМТ-ийн ажилчид 2 ээлжээр ажиллаж байна. 1-р ээлжийн 8 ажилчид 14 хоног ажилласан. 2-р ээлж 04 сарын 27 ны өдрөөс 6 хүн ажиллаж байна. Нэмэлтээр жолооч -2, ариутгагч -1 авч ажиллуулсан. Ариутгал халдваргүйтгэлийг 30 айл өрх, ААН-д хийсэн. Халдвартай хог хаягдал 312 кг, энгийн хог хаягдал 65 кг шатааж булж устгасан. Түргэн тусламжийн дуудлага 71 ирснээс алсын дуудлага -26, ойрын дуудлага

Соёлын төв: Цар тахалтай холбоотой мэдээ мэдээлэл 15, соён гэгээрүүлэх мэдээ мэдээллийг 12 удаагийн давтамжтайгаар хүргэн 450 иргэдийн хандалт авч ажилласан. Мөн нийтийн номын сан цахим хаягаар цахим ном уншлагын групп үүсгэн иргэдэд цахимаар ном унших нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.

Сумын онцгой комиссоос Соёлын төвийг 3.28-ны өдөр тусгаарлан ажиглах байр болгож тусгаарлалтын байрны бэлэн байдал бэлтгэл ажлыг хийж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

ЕБС: Коронавируст халдвар /сovid-19/-ийн цар тахалтай холбоотойгоор сумын 3 хэсэгт буюу Агийн овоо, Тугийн овоо, Рашаантын постонд тус сургуулийн 39 албан хаагч өдөр бүр нэгдсэн хуваарийн дагуу эргүүл постод хяналт хийж ажиллаж байна.

Дотуур байранд сууж байсан нийт 30 сурагчийг 3 удаагийн ПСР шинжилгээнд хамруулсны дараагаар эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн.

Тус сургуулийн нийт багш ажилчдын зүгээс Сумын онцгой комисст 940.000 төгрөгийн хандив өгсөн.

Аймгийн уран илтгэлийн аварга шалгаруулах “Оюуны давалгаа” уран илтгэлийн тэмцээний сүүлийн шатанд тус сургуулийн багш нарын бэлтгэсэн сурагчид багаараа 1-р байр эзэлж 8-р ангийн 2 сурагч шилдэг илтгэгчээр шалгарлаа.

БСШУЯ-аас зохион байгуулсан цахим даалгаварын сан бүрдүүлэх “Их нүүдэл сургалт”-д тус сургуулийн 52 багш хамрагдсан.

“Боловсролын чанарын шинэчлэл 5 төсөл”-ийн хүрээнд тус сургуулийн зүгээс “Бага боловсролын чанар хүртээмжийг сайжруулах” төслийг боловсруул байна.

Хүүхдийн цэцэрлэг: Боловсролыг тасралтгүй үргэлжлүүлэхийн тулд бүлгийн багш нар анги бүлгийн группээр эцэг эхчүүд болон хүүхдүүдтэйгээ тасралтгүй холбогдож, “Теле хичээлийг тасралтгүй үзүүлэх” арга хэмжээг өөр өөрийн арга барилаар удирдан зохион явуулж байна. Мөн бүлгийн группээр дамжуулан нэмэлт дасгал даалгавар, нийт 59 цахим хичээлүүдийг бэлтгэн хүргэж ажиллаж байна. 1-р долоо хоног болон 2- долоо хоногийн Теле хичээлийн тоон үзүүлэлтийг бүлэг тус бүрээр гарган багш нарт танилцуулснаар бүлгийн багш нар бүлэг бүрийнхээ үзүүлэлт дээр ажиллаж теле хичээлийн үзэлт нэмэгдэж байна.

Эхний 7 хоногийн 1 дэхь өдөр теле хичээлийн үзэлт 53, 2% тай теле хичээлээ үзэж чадаагүй 117 хүүхэд байсан бол 5 дахь өдөр теле хичээлийн үзэлт 66, 8% тай үзэж чадаагүй 83 хүүхэд байна. Харин 2- р долоо хоногийн хувьд теле хичээлийн үзэлт 74, 4% тай 7, 6%-иар өссөн байна. Теле хичээлээ үзэж чадаагүй 64 хүүхэд байна.

Хөдөлмөр эрхлэлт: Нийтийг хамарсан ажлын Хог цэвэрлэгээний төслийг ХХҮГ-ын төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүргүүлсэн. Ажил хайгч 5 иргэний мэдээллийг сэргээсэн.

Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: 2021 онд хөгжүүлэх 30 өрхийн дэлгэрэнгүй судалгааг хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн. Нийгмийн халамжийн тэтгэвэр 59 иргэнд ehalamj системээр олгогдсон. Олголтыг тулган баталгаажууллаа. ХЭБҮ-гээр 69 өрхийн 315 иргэний 3,760,0 мян төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Хүнсний олголтыг түгээлтээр хүргэж байна.

Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр: Мөнххаан суманд COVID-19 өвчин гарсантай холбогдуулан халдварын хүрээг тархахаас урьдчилан сэргийлж, сумын онцгой комиссын даргын баталсан “Нэг өрх - Ариутгалын халдваргүйтгэл” аяны хүрээнд 4 хэсэг гарган 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 4-р сарын 19-ний өдөр сумын төвийн 4 байрын бүх өрхүүдэд ариутгал халдваргүйтгэл хийж ажилласан. Энэ аяны хүрээнд бүх өрхийн ОО болон гадна болон дотор орчинд ариутгал халдваргүйтгэл хийж дархлааг дэмжих зорилгоор өрх бүрт VITAMIN-C, 5ш, белизна 1ш- ийг өгч ариутгал халдваргүйтгэл хийх зөвлөмж чиглэлийг өгч ажилласан.

1. Нийт 525 өрхийн ОО болон гадаад орчны 7350 м.кв талбайд халдваргүйтгэл хийж, 22.2 кг Hi сор8 суперкилл бодисыг зарцуулсан.
2. COVID-19 өвчний тусгаарлалтын дэглэм сахиж байгаа 36 өрхөд зөвлөмж өгч хашааны хаалганд нь таних тэмдэг байрлуулсан.
3. Нийт 525 өрхөд 525 ширхэг Белизна, 2625 ширхэг VITAMIN-C –г хүргэлтээр олгосон.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр: Ковид-19 цар тахлын тархалттай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж 5 багийн дарга нар анхааруулах санамжийг хувиан 569-н өрхөд анхааруулах санамжийг өгч гарын үсгийн баталгааг авч ажилласан. Мөн хөдөөний 4 багийн засаг дарга нар түймрийн эрсдэлтэй газарт нутаглаж байгаа айл өрхүүдэд утсаар мэдээллийг өгч ажилласан.

Хээрийн түймэр гарах өндөр магадлалтай Баянцагаан 3-р багийн 21 өрх, Баянтэрэм 1-р багийн 33 өрх, Баян-уул 2-р багийн 15 өрхийн утасны жагсаалт гаргуулж авсан.

Газар зохион байгуулалтын чиглэлээр. 4 сард 12 иргэний өргөдөл цахим системд авч бүртгэсэн. мөн төлбөрийн орлого нэмэгдэж 8 нэхэмжлэлийн газрын төлбөр 3870.000 төгрөгийн төлбөр орлого орсон.

Наран:

Сумын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна.

Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 3 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн байна. Шийдвэрлэлт 100 хувьтай.

Боловсролын чиглэлээр: Ерөнхий боловсролын багш нар онцгой нөхцөлд сурагчдад хичээлийг хуваарийн дагуу цахимаар орж 7 хоногт 13 багш, 45 цахим хичээл зохион байгуулж, 200 сурагчид хамрагдаж байна.

Цэцэрлэгийн хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын 6 чиглэлээр даалгавар боловсруулан 110 эцэг эхэд өгч хүүхдийнхээ хийж байгааг зураг болон бичлэг болгон бүлгийн цахим хаягт байршуулан эргэх холбоотой ажиллаж байна.

“Ковидын үеийн хүүхэд хамгаалал” цахим уриалгыг зохион байгуулж 26 хүүхэд оролцлоо.

Мал эмнэлгийн чиглэлээр: Нийтийн эрүүл мэндийн хамгаалах, орчны эрүүл ахуйг сайжруулах, халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 13 аж ахуй нэгж, байгууллагын гадна талбай, 21 айл өрх, нийтийн эзэмшлийн нийт 21.000 мкв талбайд ариутгалын ажлыг хийлээ.

Байгаль орчны чиглэлээр: Хаврын хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан үүсэж болзошгүй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2-р багийн иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгч гарын үсгийн баталгааг авч ажиллалаа. Мөн сумын группуудад хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг өгч нийт 2341 хүний хандалт авсан байна.

Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран аюултай хог хаягдлын цэгийг сумын нэгдсэн хогийн цэгт барьж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Ажил зуучлалаар 19 иргэнийг, 18 ажил хайгч иргэдийн мэдээллийг сэргээсэн.

Оффисын орчинд ажиллагсдыг "КОВИД-19"-ийн халдвараас хамгаалах зөвлөмж шторкийг 5 төсөвт байгууллагын цахим хаягт байршуулсан.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж асаргааны тэтгэмж сунгуулах 2 иргэн, шинээр асаргаа тогтоолгох 1 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. 4 сарын 20-ны байдлаар 55 иргэнд, 9 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Гэрийн ажиглалтаас гарч буй иргэдээс 8 дахь хоног дээр түргэвчилсэн шинжилгээ хийж сөрөг гарсан тохиолдолд ажиглалтаас гаргаж нийт-72 түргэвчилсэн хийж бүгд сөрөг гарсан. Гэрийн ажиглалтад 12 иргэн байна.

Газрын харилцаа: Газрын хэмжээ талбай өөрчлөх-1, газар шинээр эзэмших - 2 өргөдлийг цахимаар хүлээн авч бүртгэн, өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар улсын бүртгэлийн газар луу захиалсан. 1 иргэний газар өмчлөх болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг улсын бүртгэлд захиалж гаргуулан бичилт хийж хувийн хэрэгт архивлаад байна.

2021.03.23-ны өдрийн А/22 тоот захирамжаар 4 дүгээр сарын 26-27-ны хооронд явагдах нийт 7 байршилд газрын дуудлага худалдааг зарлан цахим биржид зураг, байршил зарыг оруулсны дагуу, бүртгэлийн хугацаа эхэлж 4 сарын 19-ны өдрөөс эхлэн оролцогчдыг бүртгэж дуудлага худалдаанд цахим орчинд хэрхэн оролцох заавар зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Суманд өрхийн үйлдвэрлэл өргөжүүлэх, иргэдийн орлого ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлого ажлын байр нэмэгдүүлэх, сумын бизнес орчинг сайжруулах зорилгоор сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах хүсэлтэй иргэдийн 6 төслийг хүлээн авсан.

Төсөв төрийн сангийн чиглэлээр: 2020 оны жилийн эцсийн Санхүүгийн нэгтгэсэн тайланг 2021 оны 3 сарын 5-25-ны дотор Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж баталгаажуулж, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланг тушааж “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажилсан.

Онгон:

Төрийн удирдлагын чиглэлээр: Коронавируст цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд 4 удаа сумын Онцгой комиссыг хуралдуулж цаг үеийн асуудлаар холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллаа.

Суманд корона вирусын 11 тохиолдол бүртгэгдэж сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/44 тоот захирамжаар Тэг зогсолт хийх шийдвэр гаргаж ажиллаж байна.

Цар тахлын үед нийт 5 суурин пост, 18 албан хаагч хуваарийн дагуу эргүүл хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байна. Давхардсан тоогоор 57 албан хаагч Онцгой нөхцөлд ажиллаж байна.

Хууль эрх зүй: Цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрүүдийг ард иргэдэд сурталчилах ажлыг Сум дундын эмнэлэг, Мэдээлэл сургалт сурталчилгааны багтай хамтран зохион байгуулж, 150 ширхэг тараах материал, 50 ширхэг анхааруулга, заавар зөвлөмжийг бэлтгэн иргэдэд тарааж ажиллаа.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал: Сургууль цэцэрлэг ажиллахгүй байгаа нөхцөлд Аймаг сумаас зохион байгуулж буй цахим уралдаан тэмцээнүүдийг 3 удаа зохион байгууллаа.

Нэгдүгээр ээлжийн вакцинийг хуваарийн дагуу бүх төрийн албан хаагч, Онцгой байдлын албан хаагчидад бүрэн тарьж дууссан.

Хөдөө аж ахуй, байгаль орчин: Мал амьтаны сэг зэмийг устгах ажлын хүрээнд сум тойрсон үхсэн мал 52 ширхэг, нохой муур, зэрлэг амьтан 16 ширхэгийг ОНӨААТҮГазар,

багийн Засаг дарга нар, сургуулийн барилгын албан хаагчидтай хамтран бүрэн цэвэрлэж ариутгал халдваргүйтгэл хийж устгалаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу бүх өрхийг мод тарих аянд уриалж нэг өрх нэг мод аян зарлаж Сүхбаатар аймгийн Мод үржүүлгийн комипаниудтай хамтран ажиллаж байна.

Сүхбаатар:

Төрийн удирдлагын чиглэлээр: 3 дугаар сарын 26-27ны өдрүүдэд сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 1-р багт, Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 5-р багт, аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч И.Батсүхээр ахлуулсан ажлын хэсэг 3-р багт тус тус ажилласан. Ажлын хэсэгт байгаль орчны байцаагч, татварын байцаагч зэрэг албан хаагчид орж, малчны хотонд төрийн үйлчилгээг үзүүлж ажилласан.

“Ковид-19”-ын вакцинжуулалт 4 сарын 5-нд эхэлсэн бөгөөд эхний өдөр онцгой комиссын гишүүд, 4 сарын 6-нд Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчид вакцинд хамрагдаж эхлэхэд халуурсан зовиуртай нэг ажилтан эрүүл мэндийн үзлэгт орсон. Уг иргэнээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авахад эерэг гарч, ПСР-ын шинжилгээ явуулж 4 сарын 9-нд анхны тохиолдол батлагдсан.

Анхны тохиолдол батлагдсан өдрөөс эхлэн сумын төвд амьдарч байгаа иргэдийн судалгааг багийн Засаг дарга нараар гаргуулж нийт 635 иргэнийг шинжилгээнд хамруулах зорилгоор “Нэг иргэн-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулсан. Судалгаанд бүртгэгдсэн иргэдээс 32 иргэн суманд байхгүй байсан, 1 иргэн шинжилгээ өгөхөөс татгалзсан, нэмэлтээр 27 иргэн хамрагдаж нийт 628 иргэнийг түүргэвчилсэн оношлуураар шинжилгээ авсан.

4 сарын 9-өөс 19-ний өдрүүдэд зохион байгуулсан “Нэг иргэн-Нэг шинжилгээ”-нд хамрагдалт 98.8 хувь.

Мөн батлагдсан тохиолдын ойрын хавьтал, ойрын хавьтал дээр бүргэгдээгүй боловч ойролцоо нутаглаж, малын ус, бэлчээр нэг дор иргэдээс урьдчилсан сэргийлэх зорилгоор нийт 506 ПСР-ын шинжилгээг авч шинжилгээнд хамруулсан.

Сумын хэмжээнд давхардсан тоогоор 1134 иргэнийг шинжилгээнд хамруулаад байна.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр: 4-р багийн нутаг Зараагийн зам дагуух хогийг цэвэрлэж 4н тн хогийг сумын нэгдсэн хогийн цэгт хаясан.

Мөн Нагаранз, Олгой булаг ХХК-ын нүүрс тээвэрлэлтийн замд хяналт шалгалт хийж заавар зөвөлгөө өгч хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон.

Хөдөөгийн 3 багийн баг тойрох ажлын хэсэгт ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 300 боршуур, Хог хаягдалын хууль тогтоомжийн 200 брошурыг тус ажлын хэсгүүдэд өгч 300 орчим 16-аас дээш насны малчин иргэдээс ой хээрийн түмэр гаргахгүй гэсэн гарын үсгийн баталгааг авч ажилласан.

Дархан хаан уулын хог хаягдалыг цэвэрлэж, тус ууланд нутагшиж байгаа аргал хонинд хужир мара тавих ажлыг зохион байгуулсан.

Түвшинширээ:

Төрийн удирдлагын чиглэлээр:

Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар болон аймгийн Засаг даргын 2021 оны А/199 “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”, А/201 “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” захирамжууд, аймгийн Онцгой байдлын газраас өгсөн цаг үеийн холбогдолтой үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэх үүднээс сумын Засаг даргын 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/40 “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай”, 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/42, 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/47 “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” захирамжууд тус тус гаргаж түргэвчилсэн

оношлуураар “Сул эерэг” үзүүлэлттэй гарсан иргэдийн шинжилгээний PCR шилжилгээний хариу гартал тус бүр 3-4 хоногийн хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоож, сумаас орох гарах болон сум доторх хөдөлгөөнийг зогсоож хүнсний дэлгүүрүүдийг хүргэлтийн үйлчилгээний зохион байгуулалтанд оруулан ажиллалаа.

03 дугаар сарын 26-аас эхлэн сумын орох гарах хөдөлгөөнийг хязгаарлан, сумын эргэн тойрон 6 хяналтын, 2 хөдөлгөөнт, нийт 8 пост гаргаад байна. Хөдөлгөөнт постуудад төрийн байгууллагын албан хаагчид жижүүрлэн ажиллаж байна. Хөл хорио тогтоосонтой холбогдуулан хөдөлгөөнт болон хяналтын постуудын бензин шатахууны зардалд одоогоор 3,0 сая төгрөгийн зардал гараад байна.

Хүн ам, нийгмийн хамгаалал: 2021 оны 04 дүгээр сарын байдлаар он гарсаар нийт 25 хүүхэд шинээр мэндэлж, 7 гэрлэлт бүртгэгдэн, нас баралт 3, 35 иргэний үнэмлэх шинээр олгогдож, иргэний бүртгэлтэй холбоотой 102 лавлагаа гаргасан байна. Сумын нийт хүн ам 3411, сумын нийт өрх 975, хүн ам, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна.

Хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээг бэхжүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Ковидын үеийн хүүхэд хамгаалал” нэрийн дор Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газар, тус сумын Хүүхдийн цэцэрлэг төлөвлөгөө гаргаж 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” “Хүүхэд хамгааллын тухай хууль” “Ковид-19 зөвлөмж” гарын авлагуудыг бэлтгэн хэвлэж сумын иргэд болон аж ахуйн нэгжүүдэд тараан сурталчилсан. Мөн хүүхдүүдээс санал асуулга авч холбогдох албан тушаалтанд уламжилсан.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн болон сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороодыг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тохижилт үйлчилгээний зориулалт бүхий ковш болон бусад техник, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар худалдан авах хог зөөврийн машины нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерүүдийг тус тус зарлаад байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2022 онд суманд хийгдэх ажлын санал асуулгыг цахим хэлбэрээр авч эхлээд байна.

Тус сумын төсөвт байгууллагуудын болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгдсэн тайланг бэлтгэн Санхүү, Төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Сүхбаатар аймаг дахь төрийн Аудитын газарт тус тус нэгтгүүлэн тайлагнаж бүх байгууллагууд зөрчилгүй санал дүгнэлт авч ажилласан.

Сумын ИТХурлын 2018 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан газрын төлбөрийн итгэлцүүрийн дагуу газар эзэмшигч ИААНБ-уудын газрын төлбөрийн ногдуулалтыг гаргаж, ИААНБ-уудын 2020 оны газар эзэмших гэрээг дүгнэж, 2021 онд газрын төлбөр болох 3 сая гаруй төгрөгийг төвлөрүүлээд байна.

ГХБХБГазарт Хаягийн нэгдсэн цахим системд хаяг оруулах ажлыг зохион байгуулж, сумын хэмжээний 64 гудамж, 565 байр зүйн нэгж талбар, 298 байр зүйн барилга, Кадастрийн мэдээллийн сангийн нэгж талбар 96.6 хувьтай, кадастрийн мэдээллийн сангийн барилга 95.4 хувийн гүйцэтгэлтэй орууллаа.

Хөдөө аж ахуй, байгаль орчин: Энэ сарын байдлаар сумын хэмжээнд төл бойжилт 67,9% -тай байна.

Сумын төвийн нэгдсэн хогийн талбай хэмжээ, хог хаягдлын эзэлхүүнийг тогтоох ажлыг аймгийн БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж, дрон ашиглан зураг авалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тус сумын ЗДТГазар ХХҮХэлтэстэй хамтран амьжиргааг дэмжих хөтөлбөрийн

хүрээнд өрхийн хүнсний талонд хамрагдсан айл өрхийн судалгааг үндэслэн 10 өрх тус бүрээс 1 хүн татан оролцуулж үхсэн мал амьтны сэг зэм, эзэнгүй хог хаядлыг устгах ажлыг 2021 оны 04 дугаар сарын 05-ны өдрөөс 10 хугацаатай зохион байгуулан сумын нэгдсэн хогийн цэг, цэгийн ойр орчим болоод сумын төвийн ногоон бүс 5 км радиус тойрогт үхсэн малын сэг зэм, хог хаядлыг цуглуулж ариутгал халдваргүйтгэл хийж булж устгах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Устгалын цэгт нийт 273 тооны үхсэн мал, 16 сэг зэм, 3 тонн хог хаягдал хог хаядлыг зөөж тээвэрлэн ариутгал халдваргүйтгэл хийж булж устгах ажлыг хийсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах үүднээс малчид, ард иргэдэд хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар гарын авлага тарааж цахим хуудсаар мэдээллийг хүргэн ажиллалаа.

Татвар: Улсад төвлөрүүлэх төвлөрсөн төсвийн орлогод 1000,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1984,0 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 198,4 хувиар буюу 984,0 мянган төгрөгөөр, аймаг төвлөрүүлэх татварын орлогод 22775,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 28545,6 мянган төгрөгийг төвлөрүүлж өлөвлөгөөг 125,3 хувиар буюу 5770,6 мянган төгрөгөөр, сум орон нутгийн татварын орлогод 3826,8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 7501,4 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 196,0 хувиар буюу 3674,6 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Нийт татварын орлогод 27601,8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 38031,0 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 137,8 хувиар буюу 10429,2 мянган төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан.

Хөдөлмөр, нийгмийн халамж: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд сумын хөдөлмөрийн насны ажилгүй иргэн ажил хайгч 44 иргэний мэдээлэл бүртгэлтэй байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 26 өрхийн 117 иргэн хамрагдаж байгаа байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний асаргааны тэтгэмжид шинээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ахмад 3 иргэнийг тэтгэмжид хамруулсан.

ОНОТХҮ-ний бүлгийн төслийг сумын цахим группт зарыг тавьж, мөн багийн иргэд нийтийн хурлаар иргэдэд мэдээллийг өгсөн.Одоогоор 4 өрхийн 4 бүлгийн төслийг хүлээн аваад байна.

Нийгмийн даатгал: ЭМД-д 32 хүний 1873,5 төгрөг, СДД-д 54 хүний 8416,6 төгрөг төвлөрүүлэв. НДШ-д 1-н байгууллагын 109,2 төгрөгийн орлого орж байна. Одооны байдлаар НДШ бүрэн ороогүй байна. 04 сарын тэтгэвэрт 2 банкаар 412 хүнд 142397,3 сая төгрөгний тэтгэвэр олгосон. Тэтгэмжид 5 хүнд 6916989 төгрөг олгосон. Оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0, жирэмсэн амаржсны тэтгэмжид 2 хүний 157758 төгрөг олгосон. COVID-19 буюу цар тахалтай холбоотойгоор ЗГ-аас ААНэгжүүдийг НДШимтгэлээс чөлөөлнө гэсний дагуу 16 ААНэгжийг чөлөөлөлтөнд хамрагдуулсан.

ЕБС: “Дэлхийн том хичээл” үндэсний хэлэлцүүлгийн хүрээнд зохион байгуулж буй хичээлийн хөтөлбөрийн уралдаанд НУЗАН, БУЗАН-ээс нэг нэг хичээлийн төлөвлөлт боловсруулан БСУГ -т явуулснаас 11-р ангийн газарзүй судлагдахууны “Дэлхийг инээлгэцгээ” хичээлийг БМДИ шалгаруулалтанд оролцуулахаар хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн ЕБС-д лаборатори байгуулж, сургалтын орчин сайжруулахаар тусгасан “Мэдээллийн технологийн ” кабинетыг компьютержүүлэх төслийг бичиж илгээлээ.

Сургуулийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх үүднээс мод тарих суулгацын нүхийг бэлдэж байна. Өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан сургуулийнхаа хойд талбайд 3x8 харьцаатай ногооны хүлэмжийг барьж ногоо тарихад бэлэн болголоо.

Хүүхдийн цэцэрлэг: Хүүхдээ сонсох өдөрт зориулан 11 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан бүлэг бүр нэг арга хэмжээ зохион байгуулж, ахлах, бэлтгэл бүлэг хэлэлцүүлэг

зохион байгуулж байгууллагаас нэгдсэн уриалга гаргаж ажилласан. Ажилчдын дунд “Та хүүхдээ сонсож чадахуу?” гэсэн хэлэлцүүлэг хийлээ.

Тогтвортой хөгжил зорилтын хүрээнд хог хаягдалын ангилан ялгалтыг хүүхэд бүрт зааж сургаж, бүлэг бүр 5 төрлийн хог хаягдалын савыг байршуулж хүүхдэд дадал хэвшил эзэмшүүлэхийн тулд карт хийж ангилан ялгалтыг ойлгуулж хэвшлээ.

Өдөр бүр эцэг эхтэй эргэх холбоотой байж теле хичээлийн үзэлтийн мэдээг 11 цагт тогтмол авч нэгтгэн БСУГ-т өгч байна. Мөн бэлтгэл бүлгийн багш нарт БСУГ-с 4 бүс болгон хувааж 7 хоногоор хичээлийн сан үүсгэж эцэг эхэд халдвар хамгаалалын дэглэм баримтлан гэрээр хүргэж хичээлийг хийлгэж эргэх холбоотой ажиллаж байна. Үүн дээр нь тулгуурлан манайх бүх бүлгүүддээ 7 хоног хичээлийг нь цаасаар бэлтгэн хүүхдэд өгч дасгал даалгавар хийлгэж эхэлсэн.

Соёлын төв: Төв талбай, болон гудамж, дэлгүүрүүдийн үүдэнд чанга яригчаар Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөөг ард иргэддээ тэгш хүртээмжтэй түгээхийн тулд гудамж нэг бүрээр явж танилцуулж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 414, алсын дуудлага 18, гэрийн дуудлага 45, хэвтэн эмчлүүлэгч 4, нас баралт 0 байна.

Коронавирус халдвар /Ковид-19/-ийн эсрэг эхний ээлжийн вакцинжуулалтад ЭМТ, сумын Онцгой комисс, ЕБС болон хүүхдийн цэцэрлэгийн 144 ажилтан албан хаагчдыг хамрууллаа.

ЭМТ-д 1,0 сая төгрөгийн түргэвчилсэн оношлуурыг Засаг даргын нөөц хөрөнгөөс худалдан аваад байна.

Эрүүл мэндийн яамнаас коронавирусын цар тахлын хүрээнд Covid-ийн тусгаарлах байранд сул эерэг гарсан 3 иргэнийг тусгаарлаж халдвар хамгааллын дэглэмийг сахиж тусгаарлалтын хугацааг дуусгаж гэрийн тусгаарлалтад шилжүүлээд байна. Мөн тусгаарлах байрны хараа хяналтыг сайжруулах зорилгоор үүдний коридор болон хамгаалалтын хувцас өмсөх, тайлах өрөөнүүдэд хяналтын камер байршуулж эмчлүүлэгч болон халдвар хамгаалаллын хувцас өмсөж тайлаж байгаа ажилчидыг хянаж ажиллаж байна.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Засаг даргын 2021-04-12-ний өдрийн А/37 тоот Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авах зарим арга хэмжээний хүрээнд хөл хорио тогтоосон

Санхүү алба: Орон нутгийн орлогын биелэлт: /04 сарын дүнгээр мян.төг /

• Үйл ажиллагааны орлого	2432,5
• Шууд бус орлого	1233,0
• Хөрөнгө борлуулсаны орлого	700,0
• Хөрөнгийн орлого	3834,0
• Буу	60,0
• Улсын тэмдэгтийн хураамж	893,3
• Хог хаягдал	1200,0
• Хүү торгуулийн орлого	3436,0
• ТТАМ	
• Бусад нэр заагдаагүй орлого	20000,0
• Ан амьтны нөөц ашигласаны төлбөр	
• Газар	2275,8
• Дүн	36064,6

Байгаль орчны чиглэлээр: Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2 ААНэгж, 2 иргэний уст цэг хийж зөрчил дутагдлын талаар албан шаардлага хүргүүлэн, заавар, зөвлөмж өгсөн.

"Эх дэлхийн өдөр"-т зориулж "Хар ямаатын БНГазрын захиргаа"-тай хамтран айл өрхийг хашаандаа төрөл бүрийн мод тарихийг уриалах, дэмжлэг үзүүлэх, жишиг гудамж бий болгох арга хэмжээний хүрээнд 53 өрхөд монос, гүйлс, үхрийн нүдний суулгац 240 ширхэгийг суулгаж өгч, мод тарих арга, арчилгаа, усалгааны хуваарийн талаар зөвлөгөө өгсөн.

Хөдөө аж ахуй: Сумын Онцгой комиссын 5 дугаар хурлын шийдвэрээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу 16 ААНэгж, дэлгүүрүүдийн дарга эрхлэгч нартай уулзалтыг хийж Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хүнсний худалдаа эрхлэгчдийн 22 худалдагчийг вакцинд хамруулахаар судалгааг гарган аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

55 өрхөөс үрийн төмсний захиалгыг авч аймгийн ХХААГазарт 1тн төмсний захиалгыг хүргүүлсэн.

Сумын хэмжээнд том малын зүй бусын хорогдол тэмээ – 3, адуу – 279, үхэр - 568, хонь -1644, ямаа – 1557, нийт – 4051 толгой мал хорогдож сумын нийт малын 2.9%-ийн хорогдолтой байна. Мөн мал төллөлт 52%-тай байна.

Мал эмнэлэг: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны 02 тоот албан даалгаврын дагуу мянганы зам дагуу сумын төвийн ойролцоо хаясан 1841 малын сэг зэм, 3.8 тн хог хаягдлыг цуглуулан хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлэн, 25480м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна.

Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр: Ажил хайгч 10 иргэдийн мэдээллийг "LIMS" праграммд шинэчилж бүртгэсэн.

Санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 2020 оны эргэн төлөлт төвлөрүүлэлт дутуу хийсэн 11 иргэнд мэдэгдэл хуудас хүргүүлж 4836750 төгрөгийг төлүүлсэн. Мөн 2021 оны 1-4 сард эргэн төлөлт хийх иргэдээс 2800000 төгрөгний эргэн төлөлтийг төвлөрүүлээд байна.

"Түмэнцогт суманд үйлдвэрлэв" борлуулалтын цэгт 12 иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулж нийт 1230000 төгрөгний борлуулт хийж тус цэгийн цахим хуудсанд мэдээ, мэдээлэл оруулж иргэдэд бараа бүтээгдэхүүнийг сурталчилж ажиллаж байна.

Цэцэрлэг: "Дэлхийн том хичээл - Тогтвортой хөгжлийн боловсрол" хичээлийн хэлэлцүүлэг төлөвлөлтийн уралдаанд бэлтгэн оролцож, хойд бүс, аймгаасаа шалгаран улсад оролцож байна.

Багш ажилчид Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх "Синафарм" үйлдвэрийн вероселл вакцинжуулалтад нийт 25 багш ажилчдаас 24 нь буюу 96% нь хамрагдлаа.

Дэлхийн мод тарих өдөрт зориулан байгууллагынхаа багш ажилчдын дунд "Хог биш- Мод тарья" чэллэнж зарлан одоогийн байдлаар 20 мод бут, албандаа огурцины суулгац- 60ш, помидорийн үрслүүлэг-40ш, тасалгааны цэцэг- 21ш, гадна цэцгийн мандлын суулгац- 180 ширхэгийг суулгаж бэлдлээ.

Ерөнхий боловсролын сургууль:Бага ангийн 282 сурагчдыг Монгол хэл, математикийн хичээлээр анги удирдсан багшаар дамжуулан оношлож дүгнэлт хийж, сайжруулах талаар багш нарт үүрэг өгч ажиллаж байна. 1-5-р ангийн 10-н бүлгийн дунджаар Монгол хэл 62.6%, математик 54.7%-ийн гүйцэтгэлтэй байна.

УОК, БШУЯам, Аймгийн БСУГ, СОК-ын өгсөн үүрэг даалгавар, ажлын чиглэлийн дагуу ажиллаж байна. Суралцагч, эцэг эхчүүдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс сургуулийн цахим групп, 22 бүлгийн эцэг эхчүүдэд 30 гаруй төрлийн зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажилласан байна.

ЭМТөв: Гэрийн ажиглалтад -28. Энэ сард голомт бүхий бүс нутгаар зорчсон 108 иргэнийг гэрийн ажиглалтад авч тогтмол хянаж түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж ажиллав.

Шинжилгээ–Түргэвчилсэн-154, PCR-14. Шинжилгээгээр гарсан эерэг тохиолдлуудын хавьталд тандалт хийж 124 иргэний нарийвчилсан судалгааг гаргасан.

Ковид -19 халдварын эсрэг дархлаажуулалтад 141 иргэнийг хамруулан хийсэн.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын батлагдсан тохиолдлын ойрын хавьтал байгаатай холбогдуулан дам хавьтлын 152 иргэний судалгааг гаргаж гэрийн ажиглалтад авч хянаж байна.

13 байгууллагын 1100мкв талбайд халдваргүйтгэл хийсэн. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын зорчсон маршрутын дагуу объектуудад 1582 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн.

Халзан:

Тамгын газар: Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор нийт байнгийн 4 постонд ээлжээр 16 албан хаагч, хөдөлгөөнт эргүүлд цагдаагийн 1 албан хаагч ажиллаж байна. Зэргэлдээх сумдад халдварын тохиолдол бүртгэгдэж байгаатай холбогдуулж сумын Онцгой комиссын 9 дүгээр хуралдаанаар хөдөө, багт тавих хяналтыг чангатгаж, голомттой бүсээс иргэдийн татан авалтыг бүр мөсөн зогсоон, сумын төвд авто машины хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээг зохион байгууллаа.

Сонгуулийн хорооны салбар зөвлөлийг 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулаад байна. Хэсгийн хороодыг 5 дугаар сард байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Төсөв, санхүү: Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 37532,3 мянган төгрөг, сумын татварын орлогоор 1806,8 мянган төгрөг орж, нийт орлого 39339,1 мянган төгрөг дансанд төвлөрсөн байна. Үүнээс:

- ЗДТГ-29388,8 мян/төг
- ИТХ-5697,6 мян/төг
- Соёлын төвд-6236,7 мян/төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо.

ОНХС-ийн дансны үлдэгдэл-7763,7 мян/төг, СХС-ийн дансны үлдэгдэл-96158,8 мян/төг дансанд төвлөрөөд байна.

ЭМТ-ийн худалдан авах ажиллагааны тендерийг зарласан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ: 4 дүгээр сарын 05-25 ны хооронд Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Мэрит төсөлтэй хамтран зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сургалтад нийт 4 албан байгууллагын дарга, эрхлэгч, бичиг хэргийн ажилтан болон ЗДТГ-ын төрийн жинхэнэ албан хаагчид, төрийн үйлчилгээний албан хаагчид гэх мэт нийт 23 албан хаагч хамрагдаад байна.

Ерөнхий боловсролын сургууль: Хичээл сургалт цахим хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан багш нар ангийн группүүдэд теле хичээлийн бататгал болгон цахим хичээл бэлтгэн байршуулж, ангийн сурагчидтай эргэх холбоотой ажиллаж байна

Эрүүл мэндийн төв: 4 сард Голомтот бүс нутгаас ирсэн 86 иргэнийг “Гэрийн ажиглалтад авч ЭМТ-ийн мэргэжилтэнгүүд өдөрт 2 удаа биеийн байдлыг хянан Зөвлөгөө зөвлөмж баталгааны хуудас өгч гарын үсэг зуруулан ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэг, ЭМТ, Цагдаа, онцгой комиссын нийт 108 иргэнийг Ковид -19 өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулсан. Энэ хугацаанд нийт 70 хүнд түргэвчилсэн шинжилгээ хийсэн PCR шинжилгээг 4 явуулсан .

Хөдөлмөр халамжийн чиглэлээр: "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", Малжуулах төсөл 18-45 насны малчин өрх, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" -ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах төсөл эдгээр төслүүдийг зарлаж төсөл хөтөлбөрт хамрагдахыг хүссэн иргэдийг бүртгэн ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл: 2021 оны 04-р сарын 23-ны байдлаар нийт 18 зээлдэгч байгаагаас 2021 оны 04 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 2 хүнээс 1,2 сая н төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нийт 17 зээлдэгч нартай утсаар ярин эргэн төлөлтөнд төлөх тал дээр анхаарч ажиллаж байна.

Байгаль орчны чиглэлээр: Ой хэрийн түймрийн эрсдэлийн үнэлгээг гаргаж аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллав. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шторк, видео хичээлийг “Шинэ Халзан” группэд 3 удаа тавьж сурталчилсан байна.

Салхи, шуургатай үед ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр малчдад анхааруулах мэдээ мэдээллийг масс мессэжээр 3 удаа явуулж үүнд давхардсан тоогоор 456 иргэн хамрагдсан байна.

Нийтийн эзэмшлийн гудамж талбай цэвэрлэх хуваарь гарган Засаг даргаар батлуулан Төсөвт албан газрууд байгууллагын орчны цэвэрлэгээ хийхээс гадна нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлэн 5 тонн хогийг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэв. Уг арга хэмжээнд 6 албан газрын 65 албан хаагч оролцов.

Уулбаян:

Төрийн удирдлагын чиглэлээр: 4 сарын байдлаар шинээр төрсөн-35 (үүнээс ковидтой холбоотой хугацаа хэтэрсэн төрөлт -1), ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-1, нас барсан- 12, шинээр гэрлэсэн-18, цахим иргэний үнэмлэх захиалсан– 22, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 31, эцэг, эх тогтоолгосны бүртгэл – 4 тус тус бүртгэгдсэн байна.

2020 оны 09 сарын 01-ээс 12 сарын 31 хүртэлх төрсөний, гэрлэсний, нас барсны нотлох баримтыг файл үүсгэн бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр: Орон нутгийн орлого нийт 24856,5 мян төгрөг орохоос 11403,0 мян төгрөг орж орлогын төлөвлөгөө 45,8 хувийн биелэлттэй байна. Энэ нь уул уурхайн компаниас гэрээний дагуу орох орлого тасарсантай холбооой байна.

Шилэн дансанд 2020 оны ТЕЗ-ийн санхүүгийн тайлан, аудитийн дүгнэлт байршуулсан. Мөн статистикийн 1-р улирлын мэдээ тайланг явуулсан байгаа.

Худалдан авах ажиллагааны талаар: Сумын хэмжээнд халуун усны барилгад нээлттэй тендер шалгаруулах үнэлгээний хороо, Чийрэгжүүлэлтийн төв байгуулах үнэлгээний хороог тус тус байгуулав.

Байгаль орчны чиглэлээр: Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай болон албан байгууллага аж ахуй нэгжүүдийн гадна талбайд 2 удаа ариутгал халдваргүйжүүлэлтийг 23100 м2 талбайд мал эмнэлэгийн тасагтай хамтран хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 03-ны өдрийн 211 дүгээр тогтоолын дагуу ус, дулааны үнийг төлбөрөөс чөлөөлсөнтэй холбогдуулан 2020 оны 3 дугаар сарын усны төлбөр болох 1369800 төгрөгийг сумын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэнийг 4 газарт буцаан олгосон.

Газар зохион байгуулалт: Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авахаар материал бүрдүүлж байгаа 3 иргэнд кадастрын зураг болон холбогдох бусад мэдээллийг бүрдүүлж өгөв.

Эзэмших, ашиглах газрын эрх үүссэн 39 нэгж талбарын газрын төлбөрийн нэхэмжлэхийг үүсгэн холбогдох газруудад нь хүргэн ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын хувьд 106959 хээлтэгчээс 69409 нь буюу 64.9% нь төллөөд байна. Үүнээс ингэ-136, гүү-2396, үнээ-2416, эм хонь-41590, эм ямаа-22871 төллөөд байна. Нийт 69415 төл хүлээж авснаас төлийн бойжуулалт 100%-тай байна.

2021 оны 4 сарын байдлаар Том малын зүй бус хорогдол 324 /толгой/ гарсан байна.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр: 2021.04.22-ны байдлаар “Гүн Хүсэл”, “Хишиг”, “Өгөөж”, “Дэлгэрэх”, “Эрдэнэ-Оргих”, “Баян” гэсэн 6 аж ахуйн нэгжүүд дараах хүнсний бүтээгдэхүүний нөөцтэй байна.

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	18 тн

Гурилан бүтээгдэхүүн	185 ш
Будаа	320 кг
Хуурай/Шингэн сүү	495ш
Өндөг	920ш
Ургамлын тос	156ш
Төмс	200кг
Хүнсний ногоо	135кг
Элсэн чихэр	240кг
Давс	194кг
Савласан ус	313ш

Түлшний нөөцийн хувьд:

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	18тн 600л	5тн 200л	13тн 800л

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байхыг 2021оны 4сарын 11 өдөр аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт мэдэгдэл хүргүүлж, хууль тогтоомж зөрчих, мэдэгдлийн хэрэгжилтийг хангахгүй зөрчил гаргавал Зөрчлийн тухай хуулийн дагуу 5.13 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага оногдуулахыг мэдэгдсэн.

Сумын стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах харилцааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээг 2021оны 4сарын 8 өдөр “Гүнхүсэл”, “Өгөөж”, “Эрдэнэоргих”, гэсэн 3 аж ахуй эрхлэгч нартай хүнсний нөөц бүрдүүлэх гэрээг хамтарч байгуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021.4.10-ны өдрийн А/217 дугаар захирамжаар “2021.4.25-ныг хүртэл архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхгүй байхыг хориглосон” захирамжийн дагуу 2021.4.15-ны өдөр дэлгүүрүүдийн согтууруулах ундааны тоо ширхэгийн хэмжээг авч бүртгэл хийх, лацдах арга хэмжээг авч тусгай зөвшөөрөлтэй 4 дэлгүүрийн 410 ширхэг архи, согтууруулах ундааг лацдав.

2021.03.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 248,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

- Хэвийн зээлтэй - 10 зээлдэгчийн 70,000,000 төгрөг,
- Эргэлзээтэй зээлтэй /181-360хоног/- 5 зээлдэгчийн 47,000.000 төгрөг
- Муу буюу чанаргүй зээлтэй /360>/ - 15 зээлдэгчийн 131,800,000 төгрөг
- 7 зээлдэгчийн 48,287,470, төгрөг эргэн төлөгдөж хаагдсан.

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь 63.7% байна.

3 сарын байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 7,000,000 төгрөг орж ирсэн.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас чиглэл болгосны дагуу сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэх ажлыг зохион байгуулж, аудитын дүгнэлтийг 2021 оны 04 сарын 01-ний дотор хүргүүлсэн.

Мал эмнэлгийн чиглэлээр: Жавхлант багийн нутгийн засмал замын ойр орчимд хаясан 45 мал амьтны сэг зэм, хогийг түүж цуглуулан устгалын цэгийн нүхэнд хийж булж устгах ажлыг зохион байгууллаа. Уг ажилд Сун хун голд уурхайн машин техникийг дайчлан ажилласан.

Халдваргүйтгэлийн арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. Уг арга хэмжээнд хяналтын 4 пост, нийтийн эзэмшлийн зам талбай, авто зогсоол, шатхуун түгээх станц, албан байгууллага, аж ахуй нэгжийн 14400 м2 , зоорь агуулахын 500 м2, байр орон сууцны 3600 м2, муу усны нүх жорлонгийн 1600м2, сумын төвийн болон голомтын бүсийн айл өрхийн 25 худаг уст цэгийн 3000 м2 талбай нийт 23100 м2 талбайд эцсийн халдваргүйтгэл хийсэн.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д ажил хайгчаар бүртгэсэн 34 иргэнийг сэргээсэн.

2021 оны 04 сард Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд жирэмсэн эхийн тэтгэмжинд 4 иргэн, цалинтай эхийн тэтгэмжинд 4 иргэнийг бүртгэсэн. Хүнсний талоны 42 өрхөөс 27 өрхийн хүнс тэжээлийг олгосон. Шинээр төрсөн 2 хүүхдийн бичиг баримтыг хүлээн авч бүртгэсэн. 04-р сарын 21-ны өдөр хөдөлмөр аюулгүй байдлын сургалт зөвлөгөөн оролцсон.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 145172.7 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

СДДаатгалд 156 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 15862.5 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 120 даатгуулагчийг даатгаж 4931.2 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-21 ,тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-2 , тэтгэмж-8, ажилгүйдлын тэтгэмж-1 малчнаар ажилласан жил тотоолгох-6 нийт 43 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж , 338 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна..

Эрүүл мэнд:

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1734
2	Амбулаторийн үзлэг	796
3	Гэрийн дудлага	169
4	Алсын дуудлага	103
5	Артерийн даралт	459
6	Чихрийн шижин	586
7	Хөхний үзлэг	381
8	Эсийн шинжилгээ	9
9	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	108
10	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	113
11	Гэрийн тусгаарлалтад байгаа	18
12	Гэрийн ажиглалтад байгаа	6

Ерөнхий боловсролын сургууль :

- Сургуулийн 437 хүүхдийн эрсдэлийн үнэлгээг АУБ нараар хийлгэж эрсдэлийг тогтоов.
- Аймгийн ОБГ-с сургуулийн эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх талаар 15 багш, ажилчдад сургалт зохион байгуулж, үүний үндсэн дээр эрсдэлээ тогтоон байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлууллаа.
- Ээлтэй бодлого-Эрсдэлгүй орчин-Эрчтэй зүтгэл аяны хүрээнд эрсдэлийг бууруулах зорилгоор сургуулийн дотор талыг шатанд зориулалтын резин наав.

Хүүхдийн цэцэрлэг: Суманд “Ковид19” сэжигтэй тохиолдол илэрч 3-р сарын 29-нд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хаагдаж цахимаар хичээл сургалтын үйл ажиллагаа явагдаж хүүхдийн хамргдалт 78,3%-тай байна.

Ковид19 өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 1-р тун вакцинийг 18 багш ажилчид хамрагдаж 1 эмчийн заавараар 3 хүн жирэмсэн 81,8% нь хамрагсан

Соёлын төв: Байгууллагын цахим хуудас болон нийтийн номын сан хаягаар соёл өв уламжлалын мэдээлэл, өгүүллэг 13, тууж 2, Үлгэр 8-ыг нийтэлж 5963 хандалт авсан байна.

Соёлын биет бус өв тээгчдийн мэдээлэл болон тахилга шүтлэгт уул овоодын бүртгэлийг цахим бүртгэлд бүртгэж байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр: Засаг даргын тамгын газраас долоо хоногийн 1, 3, 5 дахь өдрийг “Хууль зүйн зөвлөгөө мэдээллийн өдөр” болгосон бөгөөд өөрсдийн болон бусад төрийн байгууллагын бэлгэтсэн хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн эх сурвалжийг дурдаж мэдээллийг “Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар” гэсэн цахим хуудсаар тогтмол хүргэж байна. Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй, мэдээллийг тогтмол хүргэж байхыг чухалчлан “Сүхбаатар аймгийн Уулбаян сумын албан ёсны мэдээ, мэдээллийн нэгдсэн групп”-ийг нээн түүгээр мэдээлэл хүргэж байна. 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн өдөр”-ийг тохиолдуулан “Гэр бүлийн тухай хууль”, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль” зэрэг хууль зүйн сурталчилгааны мэдээллийг олон нийтэд хүргэлээ.

Мөн Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хүрээнд эрх зүйн зөвлөгөө, мэдээллийн сайт e-khutuch.mn-ыг олон нийтэд сурталчилж, зөвлөгөө мэдээлэл авах боломжтой мэдээлэл нийтэллээ.

Төрийн албан хаагчдад мэргэжил, ур чадвар дээшлүүлэхэд чиглэсэн “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” сургалтад хамруулж байна. Одоогоор, тамгын газрын 7 албан хаагч хамрагдсан байна. Мөн төсөвт байгууллагын удирдах албан хаагчдыг хамруулж байна.

“Засгийн газрын хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарын нэгдсэн уулзалтын хүрээнд даалгасан ажлыг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр Засаг даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу тамгын газар болон бусад төсөвт байгууллагын албан хэрэг хөтлөлтийн байдалд үзлэг хийж, шалгалтыг хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн хариуцан зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргав.

Шинээр томилогдох дөрвөн багийн Засаг даргын хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг авилгалтай тэмцэх газарт хүргүүлсэн.

“Ковид-19”-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах түүнд тавигдах шаардлагуудыг чиглэл чиглэлээр ангилж аж ахуйн нэгж, иргэнд хүргэж ажилласан.

2020 оны 4 сарын байдлаар хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг-1, танхайрах зөрчил-1 тус тус гарсан байна.

Эрдэнэцагаан:

Төсвийн хүрээнд: Тайлант сард нийт **323** гүйлгээ хийж төрийн сангаас нийт **960,160,371.5** төгрөгний гүйлгээ гарсан.

Статистик мэдээ: Төсвийн байгууллагын ажилтнуудаас монгол бичгийн судалгаа аван Статистикийн хэлтэст хүргүүлсэн. Судалгаанд Ерөнхий боловсролын сургууль, Бичигт гаалийн газар, Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, 1-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн байгууллагуудын бүх албан хаагч хамрагдсан.

Өргөдөл гомдол 14 ирснээс шийдвэрлэсэн 8, шийдвэрлэх боломжгүй 7 өргөдлийг тус тус хариуг нь өгч ажилласан.

ERP системийн хүрээнд: ERP системийн талаар Төрийн албан хаагчдад мэдээлэл хийж нийт 44 албан хаагч хамрагдлаа.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд 34 албан тушаал, 35 төрийн албан хаагчийг бүртгэж үйл ажиллагааг эхлүүлэхэд бэлэн болсон байна.

E-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд: 4 байгууллагын 6 лавлагаа гаргаж иргэнд түргэн шуурхай үйлчилсэн.

E-Mongolia апптелкейнг гар утсанд суулгах талаар иргэнд мэдээлэл хийн ажиллаж байна.

Албаны төрийн цахим шууданг 33 мэргэжилтэн албан хаагчдад нээлгэж, шуудан хаягийг яаж ашиглах талаар зааж зөвлөж хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна.

Хээрийн түймэрэс урьдчилан сэргийлж: Гал түймэрээс сэргийлэх материал 240 ш бэлтгэн хөдөөний багийн малчдад постоор дамжуулан тараасан.

Сумаас баруун тийш 90км байрлах Дарьганга сумын Бадрах багийн нутаг Баянцагаан гэдэг газраас гарсан хээрийн түймэрт Сумын нийт төрийн байгууллагын эрчүүд 7 бүлэг, 68 малчин хамтран түймрийг унтраасан.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Ажил зуучлалаар 9 иргэнийг, 61 ажил хайгч иргэдийн мэдээллийг сэргээн лims праграммд бүртгээд байна.

2021 оны 04 дүгээр сарын 01 нээс ХАБЭА-н сарын аяны удирдамж албан бичгийг томоохон аж ахуй нэгж, төсөвт байгууллагуудад тараан өгсөн ба сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гарган ажиллах талаар мэдээллийг өглөө.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Хүнсний талонд орох хүсэлтэй 3 өрхийн судалгааг авч явуулсан. Хүнсний эрхийн бичгийн 104 өрхийн картыг төрийн банктай хамтран коджуулах жагсаалтыг төрийн банканд хүргүүлсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж асаргааны тэтгэмж сунгуулах нийт 6 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Ариутгал халдваргүйтгэл, байгаль хамгааллын хүрээнд: Сумын хэмжээнд халдваргүйтгэлийн ажлыг 2021 оны 04 сарын 3-ны өдрөөс эхлэн зохион байгуулан 42 ААН, албан байгууллагын дотор гадна ариутгал, Нийтийн эзэмшлийн талбай, жорлон агуулах зэрэгт нийт 179900 м2 талбайд хийж гүйцэтгэсэн.

Сумын хэмжээнд нийт 35 нохой, бүхэр, 7 хонь, 5 ямаа, хонины арьс 60, толгой 15 ширхэг тус тус устгалаа. 7 хоног бүр ариутгал халдваргүйтгэл, сэг зэм устгаж хогийн нэгдсэн цэгийг ковшоор түрж цэгцлэн сумын төв тойрсон эзэнгүй хог хаягдлыг ачиж байна.

ЕБС: Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн байгаль хамгаалах ЭКО клубуудын дунд зохион байгуулсан “Цагаан зээр хамгааллын чиглэлээр уншсан номынхоо талаар сэтгэгдлээ хуваалцах” уралдаанд 18 эко клуб оролцоноос манай сургуулийн эко клубын багш, сурагчид амжилттай оролцож шагналт 3-р байр эзэлсэн.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн босголтын зээлийн банкаар (KfW) дамжуулан хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөлд хамрагдаж иж бүрэн эко кабинетын багаж хэрэгсэл, ном гарын авлага бордоог хүлээн авсан.

Эцэг эхчүүдийн төлөөлөлтэй “Хүүхдийн хүмүүжилд –эцэг эхийн оролцоо” сэдэвт онлайн уулзалтыг зохион байгуулсан.

Дэлхийн том хичээл- Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хэлэлцүүлгийн хүрээнд тус сургуулийн Ахлах, бага боловсролын 1,2-р ангийн хамтын хичээл тус бүр 1, 1 хичээлийн хөтөлбөр явсанаас бага боловсролын “Хог хаягдал” сэдэвт хичээлийн хөтөлбөр аймагтаа шалгарч улсад оролцох эрх авсан.

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд арга зүйн боловсруулалт хийгдэх үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт 48

сургууль оролцсоноос тус сургуулийн багш Б. Энхтүвшин, Г. Алтанчимэг нарын боловсруулсан “Манай нутгийн соёлын өв” шинэлэг арга зүйн боловсруулалт шилдэг 2 арга зүйн төлөвлөлтөөр шалгарсан.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар